



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Мягмарсүрэнгийн БАДАМСҮРЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-13-32, Факс: 32-70-16
E-mail: badamsuren@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.05.05 № 412-03/4881
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт.....хуудастай

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



М.БАДАМСҮРЭН

Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

Н.АЛТАНШАГАЙ

С.АМАРСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР

Ч.АНАР

000030

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

О.БАТНАЙРАМДАЛ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Ж.БАТСУУРЬ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ

П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

Х.БОЛОРМАА

000030

Э.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАЛБАДРАХ

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

М.ГАНХҮЛЭГ

Х.ГАНХУЯГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Х.ЖАНГАБЫЛ

Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН

000030



С.ЗАМИРА

Б.ЗАЯАБАЛ

Ж.ЗОРЖАРГАЛ



С.ЗУЛПХАР

Ц.ИДЭРБАТ

Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ


М.МАНДХАЙ

Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН -

Т.МӨНХСАЙХАН



Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

Н.НОМТОЙБАЯР

000030

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

Г.ОЧИРБАТ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ПУНСАЛМАА

Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТҮВШИН

Б.ТУЛГА

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

Ч.УНДРАМ

Д.ҮҮРИЙНТУЯА

Н.УЧРАЛ

000030



Б.УЯНГА

Г.УЯНГАХИШИГ

Г.ХОСБАЯР



Б.ХЭРЛЭН

ДАВ.ЦОГТБААТАР

ДАМ.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЛАН



Д.ЭНХТҮВШИН

Б.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН


Д.ЭНХТУЯА

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН





УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Мягмарсүрэнгийн БАДАМСҮРЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-13-32, Факс: 32-70-16
E-mail: badamsuren@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026. 04. 15 № ЧУХ-03/3955
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн хамт санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

43
Хавсралт..... хуудастай

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



М.БАДАМСҮРЭН

000023



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Мягмарсүрэнгийн БАДАМСҮРЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-13-32, Факс: 32-70-16
E-mail: badamsuren@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.10.23 № УИХ-03/12156
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг дагалдах хуулийн төслүүдийн хамт нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдтэй хамтран боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлт авахаар хүргүүлж байна.

Хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, холбогдох тайлан, судалгаануудыг хавсаргав.

Хавсралт ~~49~~ хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



М.БАДАМСҮРЭН

000071

2025 оны 09 дугаар сарын 20 ны өдөр

**ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улс хүн амын бүтцийн хувьд 37,1 хувийг хүүхэд, залуучууд эзэлдэг харьцангуй залуу иргэдтэй улс орон юм. Тийм ч учраас хүүхдийн эрх, хамгааллын асуудалд бодлогын түвшинд анхаарч, хууль эрх зүйн орчныг тогтмол шинэчилж ирсэн хэдий ч “Бодлого хөтөлбөр, хууль тогтоомж боловсруулан хэрэгжүүлэхдээ хүүхдийн хөгжих, оролцох эрхийг бүрэн ойлгож хэрэгжүүлдэггүй, хүүхдийг хамгаалах субъект гэж харах хандлага давамгайлж байна гэж” судлаачид дүгнэжээ. Цаашид дэлхийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хүүхдийн хөгжлийн асуудлыг бие даасан байдлаар авч үзэх нийгэм цаг үеийн хэрэгцээ шаардлага үүсээд байна. Эх оронч үзэлтэй, амьдрах ухаанд суралцсан, авьяас чадвараа нээн хөгжүүлсэн, эрхээ хамгаалж чаддаг хөгжсөн монгол хүүхдийг төлөвшүүлэхэд төрийн бодлого, дэмжлэг чухал юм. Тиймээс эх орны ирээдүй хойч, хүүхэд багачуудын хөгжил, оролцоог дэмжих хууль, эрх зүйн орчин, санхүүжилтийн тогтолцоог олон улсын сайн туршлагад тулгуурлан боловсронгуй болгох дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага үүсээд байна.

1.1 Хууль зүйн үндэслэл

Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцод 1990 онд нэгдэн орж соёрхон баталсан бөгөөд 2016 онд Хүүхдийн эрхийн тухай хуулийг баталж, Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2024 онд шинэчлэн найруулан баталсан.

Эдгээр нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хамт хүүхдийн эрхийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Ийнхүү Хүүхдийн эрхийн тухай конвенц Монгол Улсын хууль тогтоомжид тусгалаа олон хэрэгжиж ирсэн.

Мөн 2016 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд уг заалтуудыг тусгасан бөгөөд эдгээр гурван хууль нь эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийн цогц хамгаалалт болно гэж зорьсон. Хүүхдийн эрхийн тухай хууль (2016) - д эрхийн талаарх өргөн хүрээний ойлголтыг тодорхойлж, үүрэг хүлээгчдийн хууль ёсны үүрэг хариуцлагыг голчлон хөндсөн бол Хүүхэд хамгааллын тухай хууль хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих зэрэг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн болно.

Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн хөгжих эрхийг тодорхойлсон боловч хангах, дэмжих зохицуулалт дутмаг, тунхагийн шинжтэй байсан. Харин 2024 оны нэмэлт өөрчлөлтөөр энэ чиглэлд хэд хэдэн зүйл, заалт нэмэгдсэн нь хүүхдийн хөгжлийг дэмжих бодлогын суурь үндэслэл болох боломжтой байна. Тухайлбал, хүүхдийн эрхийн үндсэн зарчимд хоёр хэсэг нэмсэн нь хүүхдийн хөгжлийн тухай байна. Үүнд:

- Хүүхдийг бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүйн хувьд жигд хөгжих боломжийг хангах;
- Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ нь хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх зэрэг болно.

Мөн Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхдийн хөгжих эрхийг “Хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзнэ” гэж тодорхойлсон. Энэ хүрээнд дараах долоон эрхийг заасан байна. Үүнд:

1. Хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших;
2. Хүүхэд төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших;
3. Хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах;
4. Хүүхэд шашин шүтэх, эс шүтэх;
5. Хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах;
6. Хүүхэд гэр бүл, нийгмийн орчинд өөрийгөө хөгжүүлэх.
7. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамрагдах эрхтэй байхаар заасан.

Түүнчлэн “Хүүхэд хөгжих эрхээ амралт, чөлөөт цагаараа тоглож наадах, хүүхдийн зуслан, сувилалд амарч сувилуулах, өөрийн хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг, клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах зэрэг хэлбэрээр эдэлнэ” хэмээн тусгасан. Энэ нь хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хэлбэрүүдийг тодорхойлж бодлого стандартыг батлах, санхүүгийн хөшүүргийг бий болгох үүргийг Засгийн газрын үүрэг байхаар зүйл заалтуудаас харагдаж байна. Үүнд:

- Эрүүл мэнд, спорт, боловсрол, соёл урлаг болон нийгмийн бусад үйлчилгээ нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн байна.

- Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллага үйлчилгээний бодлого, хөтөлбөртэй байх бөгөөд эрх бүхий этгээдээс баталсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллана.

- Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн, боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална гэсэн зэрэг болно.

Тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10 дах заалтад “Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж, батлуулах арга хэмжээ авах” гэж заасан.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга мөн л 2024 онд батлагдсан. Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад энэхүү хуулийн зорилго нь оршино.

Тус хуульд "Хүүхдийн сайн сайхан байдал" гэх ойлголтын салшгүй нэг хэсгийг "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчин нөхцөл" гэж тодорхойлж, хүүхэд хамгааллын тогтолцооны удирдлага, зохион байгуулалтыг голлон хэрэгжүүлэгч нь Засгийн газар байх бөгөөд "Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт хүүхдийн эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах талаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг тусгах, хүүхэд хамгааллыг тогтвортой санхүүжилтээр хангах үүрэгтэй" байхаар заасан. Тиймээс Засгийн газар нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчин нөхцөлийг бий болгох бодлогын арга хэмжээ авч, тогтвортой санхүүжилтээр хангах үүрэгтэй байхаар хуульчилсан боловч энэ чиглэлээрх бодлого, үйл ажиллагаа дутмаг хэвээр байна.

Мөн 6-18 хүртэлх насны хүүхдийн хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр бодлогын шинжтэй үйл ажиллагаа бодитоор хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоогүй бөгөөд боловсролын үйл ажиллагааны нэг төрөл болгон хууль тогтоомжид ерөнхий байдлаар тусгасан. Гэвч түүний хэрэгжилтийг хангах арга замыг тодорхой болгоогүй орхигдуулсан байна. Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28.1 дэх хэсэгт "Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх тэдэнд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээг гэр бүл, хамт олонд нь түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, хүүхдийн хөгжлийн төвийг байгуулан, хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд тусгай хөтөлбөрийн дагуу үйлчилгээ үзүүлэхийг төрөөс" дэмжинэ гэж тусгасан. Гэсэн хэдий ч хичээлээс гадуурх үйл ажиллагаа явуулдаг сургалтын болон хөгжүүлэх төвүүдийн барилга байгууламж, орчин нөхцөл хүртээмжгүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт бага байсаар байна.

Эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад хүүхдийн хөгжлийг дэмжих тэр дундаа хүүхдийн оролцоонд суурилсан хөгжлийг дэмжих, нас насанд нь тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хөгжлийн ялгаатай байдал, олон янз байдлыг харгалзан үзэж тэгш хамруулах, үүнтэй уялдаатайгаар хот ба хөдөөгийн ялгааг арилгах, багш, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудал шийдэл хүлээж байна. Иймд дан ганц салбарын бодлогоор бус салбар дундын уялдаа холбоог хангасан, улс орон даяар хэрэгжих хууль зүйн цогц зохицуулалтаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролоос гадуурх хөгжлийн үйл ажиллагаа, үйлчилгээг төрийн бодлогоор дэмжиж, хүүхдийн хөгжилд чиглэсэн төрийн үүрэг, байгууллагын хариуцлага, санхүүжилтийн тогтолцоог тодорхой болгох шаардлагатай байна.

Нөгөөтэйгүүр, өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль болон хүүхдэд зориулсан төсөв хөрөнгийн дийлэнх нь өнөөгийн нийгмийн ядуурал, нийгэмд гарч буй элдэв сөрөг үзэгдлээс үүдэн хүүхдийн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх, эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа хүүхдийг хамгаалах зэрэг үйл ажиллагаанд чиглэжээ.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдээ хөгжил төлөвшлийн үед нь ирээдүйн хувь хүн болж өсөж хөгжих боломжийг төрийн бодлого болон санхүүжилтээр дэмжих эрх зүйн зохицуулалт орхигдож иржээ. Цаашид хүүхдийн хөгжлийг дэмжих тухайлсан бодлого тэр дундаа хүүхдийн бие бялдар, авьяас чадварыг нь хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн хүүхдийн сонирхолд тулгуурласан хичээлээс гадуурх хөгжлийн үйл ажиллагаагаар дамжуулан ирээдүйн бие хүн болж төлөвшихөд төрөөс үзүүлэх

бодлогын дэмжлэгийг бие даасан хууль, санхүүжилт, хэрэгжилтийн механизмаар зохицуулах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

1.2 Практик шаардлага

Бүх шатны боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн болон техникийн боловсрол олгох чиглэлээр салбарт зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлж 2024 онд ДНБ-ий 5.7 хувьд хүргэлээ. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарт гүйцэтгэлийн үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрэн хэрэгжүүлж, 2024 онд боловсролын салбарт зарцуулах төсөв улсын төсвийн нийт зарлагын 13.7 хувьд хүрсэн бөгөөд Боловсролын салбарын төсвийн улсын нийт төсөвт эзлэх хувь 19.6 хувь болж өссөн. Гэвч НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс /НҮБХХ/ жил бүр гаргадаг хүний хөгжлийн индексээр 2025 оны байдлаар дэлхийн 193 орноос 104-т жагсаж байна.¹

Мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ/ OECD) 3 жил тутам Боловсролын олон улсын чанарын үнэлгээ- Programme for International Student Assessment (PISA) тайлангийн хамгийн сүүлийн буюу 2022 оны байдлаар 81 улсаас 51-т жагсаж байгаа² нь манай улс хүний хөгжил, хүүхдүүдийн боловсролын үзүүлэлтээр дэлхийд дунджаас доогуур үзүүлэлттэй байгааг харуулж байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар 2020-2024 оны байдлаар хүүхэд оролцсон гэмт хэрэг 811-ээс 1373, насанд хүрээгүй хүүхэд гэмт хэргийн хохирогч болсон үзүүлэлт 1101-аас 2413 болж тус тус нэмэгдсэнийг дурджээ. Насанд хүрээгүй хүүхэд гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн хохирогч болж байгаа нь нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгааж байгаагаас гадна хүүхдийн хичээлээс гадуур өөрийгөө хөгжүүлэх, цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломж дутмаг байгаатай холбоотой юм.

Хүүхэд завтай, зорилгогүй, хяналтгүй үед өөрийгөө батлах, сониуч зангаа хангах, нөлөө бүхий бүлэгт багтах хүсэлд хөтлөгддөг. Энэ нь сөрөг бүлэглэл, хорт зуршил, гэмт хэрэг рүү татагдах үндэс болдог. НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF), НҮБХХ (UNDP) зэрэг байгууллагын тайлангуудаас харахад, чөлөөт цагийн аюулгүй, бүтээлч орчин дутмаг бүс нутагт хүүхдийн гэмт хэрэгт холбогдох, хохирогч болох үзэгдэл 2-3 дахин өндөр байгааг тогтоосон.

Хичээлээс гадуурх дугуйлан сургалтад хамрагдах нь хүүхдийн хөгжилд нэн чухал төдийгүй энэ төрлийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд төрийн бодлого дэмжлэг чухал болохыг судалгааны үр дүнгүүд харуулж байна.

Тухайлбал, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын захиалгаар 2019 онд хийгдсэн “Хичээлээс гадуурх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагаа, сургалтын чанар хүртээмж, нөхцөл байдал” судалгааны тайланд “Боловсролын чанараар тэргүүлдэг улс, орнууд сургалтын хөтөлбөрийг илүү үр өгөөжтэй, сонирхолтой байлгах зорилгоор сурагчдадаа зөвхөн сургуулийн хүрээнд мэдлэг олгоод зогсохгүй, олон төрлийн сургуулиас гадуурх үйл ажиллагааг санал болгодог. Сургуулиас гадуурх үйл ажиллагаа нь нэмэлт мэдлэг олгохоос гадна харилцаа хандлага, бүтээлч байдал, бие даах байдал, багаар ажиллах гэх мэт амьдралд хэрэгцээт ур чадваруудыг бий болгодог” хэмээн онцолсон байна.

¹ Human development report 2025-UNDP

² PISA report 2022

Мөн уг судлаачид “Орчин үеийн хүүхдүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн харилцааны ур чадвар, хувь хүний хөгжил рүү чиглэсэн клубууд дутагдалтай буюу Монгол Улсад хичээллэж буй хичээлээс гадуурх үйл ажиллагааны төрлийг зайлшгүй өөрчлөх, сайжруулах хэрэгцээ, шаардлага үүссэн” дүгнэжээ.

Түүнчлэн “Дугуйлан секцэд ямар нэг байдлаар улсын төсвөөс дэмжлэг, санхүүжилт байдаггүй учраас тогтвортой, үр дүнтэй байлгах тал дээр хяналт тавихад нарийн төвөгтэй байж болох талтай гэж үзэж байна” гэсэн нь хууль эрх зүй орчны шинэчлэл хэрэгтэйг харуулж байна.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн хүрээнд зорилтот бүлэг нь 3-18 насны хүүхэд байна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Учир нь Монгол Улс сургуулийн өмнөх насны буюу бага насны хүүхдийн цогц хөгжлийн бодлогыг тодорхойлсон бөгөөд арга зүй, тогтолцоо, механизмыг ялгаатай зохицуулах ёстой насны бүлгүүд юм. Энэ хүрээнд 2023 онд Боловсрол, шинжлэх ухаан, Эрүүл мэнд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалаар Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ (2023-2026) болон уг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний баримт бодлогын баримт бичгүүдийг баталсан.

Тус бодлого нь хүүхэд бүр эрүүл, аз жаргалтай өсөж, хөгжих тэгш боломж, нөхцөлийг бүрдүүлж, тэдний ирээдүйн амьдралын чанарыг сайжруулахын тулд цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний үр ашигтай, нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх, Гэр бүл, олон нийтэд суурилсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг хөгжүүлэх, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, бага насны хүүхдийн цогц хөгжлийн салбар дундын мэдээллийн санд суурилсан хяналтыг бий болгох зорилготой байна.

3-18 хүртэлх насны хүүхдийн хөгжил, тэдгээрийг цаг заваа зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр тодорхой бодлогын шинжтэй үйл ажиллагаа бодитоор хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоогүй бөгөөд Боловсролын үйл ажиллагааны нэг төрөл болгон хууль тогтоомжид ерөнхий байдлаар тусгасан боловч түүнийг хэрэгжилтийг нь хангах арга замыг тодорхой болгоогүй орхигдуулсан байна.

Тухайлбал, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.10-т “Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна.”, мөн хуулийн 20.16. “Энэ хуулийн 20.10-т заасан хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж тусгасан.

Боловсролын чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байдлыг дурдвал Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 сарын 9-ний өдрий А/96 тушаалаар батлагдсан Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө/2021-2030/-нд “Монгол Улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан мэдлэгт суурилсан нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай иргэнийг цогцоор нь хөгжүүлэх” гэсэн зорилгыг дэвшүүлсэн. Хүн амын өсөлт, боловсролын үйлчилгээний тэгш хүртээмжтэй уялдуулан сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлж, нээлттэй боловсролын үйлчилгээний төрлийг өргөжүүлж, сургалтын тохируулгат орчныг бий болгох зорилготой байна.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 176 дугаар тогтоолоор баталсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд сургалтын хөтөлбөрийг боловсруулахад “Хамтын ажиллагаанд суурилсан байх - Суралцагч болон багшийг аюулгүй, таатай орчинд сурч хөгжих, ажиллах нөхцөлөөр хангах, сургалтын дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж, хэрэгсэл ашиглах боломжийг бүрдүүлэх, сургалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулахад төр, хувийн хэвшил, олон нийтийн оролцоог хангах” зарчмыг баримтална.

- Суралцагчийн хөгжлийг дэмжсэн сургалтаас гадуурх үйл ажиллагааг жишээ, удирдамжтайгаар санал болгосон байх;
- Суралцагч баяр баясгалантай, амар амгалан сурч хөгжих тэгш, хүртээмжтэй, аюулгүй орчныг төр, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоонд суурилж, бүрдүүлнэ;
- Суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн тоглоом наадгай, сургалтын материал, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлнэ гэжээ.

Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон төр, төрийн бус байгууллага, олон нийтийн түншлэлийг эрхэмлэнэ. Үүнд:

- Сургууль, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн хамтарч ажиллах боломжийг бий болгох, үүрэг, хариуцлага, дэмжлэгийг нэмэгдүүлнэ;
- Төр, төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцад оролцох нөхцөлийг бүрдүүлэх, идэвхтэй, бүтээлч хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ гэсэн зорилгыг тавьсан байна.

Мөн “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийг 2022 оны 8 сарын 17-ны өдрийн А/288 БСШУ-ны сайдын тушаалаар баталсан боловч зөвхөн сургууль дээр хэрэгжүүлэх байдлаар мөн хэт ерөнхий байдалтай байна. Дээр дурдсанчлан сургуулийн орчинд хүүхдийг хичээлээс гадуурх байдлаар хөгжих асуудлыг боловсролын хууль, бодлогын баримт бичигт тусгасан боловч түүний хэрэгжилтийг хангах зохицуулалт, механизмыг нь тодорхойгүй орхисон байна. Хэдийгээр сургалтын орчин болон багш нарт нь даалгасан боловч түүнийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байна. Учир нь мэргэжлийн багшийн хангалт 2023-2024 оны хичээлийн жилд 97.1 хувь болж өмнөх оны хичээлийн жилээс 1.3 пунктээр буурсан байна.

Ерөнхий боловсролын салбарт нэг багшид ногдох сурагчдын тоо дундажаар 2024 оны байдлаар хотод 23.3, хөдөө орон нутагт 19.4 болсон нь өмнөх онуудтай харьцуулахад нэмэгдэж байгаа үйл явц юм. Энэ нь багш нарын хувьд ажлын ачааллыг бий болгох, үүнээс үүдэн сурагчдыг хөгжүүлэх нэмэлт сургалтыг явуулах, ур чадвар, арга зүйгээ сайжруулах нөхцөл боломжийг хязгаарлаж байна.

Түүнчлэн Монгол Улсын ядуурлын түвшний үзүүлэлтийг 2022 оны байдлаар 2024 онд танилцуулахад нийт хүн амын 27,1 хувьтай байгаа нь тэр бүр гэр бүлүүд хүүхдийнхээ хөгжилд санхүүжилт зарцуулах боломжгүй нөхцөл

байдалтай байгаа юм.

Хүүхэд эрхээ хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, төсөв хөрөнгө гаргах талаар зохицуулалтуудыг тусгасан хэдий ч хэрэгжилт төдийлөн хангалтгүй байгаа бөгөөд хүүхдэд зориулсан төсөв хөрөнгийн дийлэнх нь өнөөгийн нийгмийн ядуурал, нийгэмд гарч буй элдэв сөрөг үзэгдлээс үүдэн хүүхдийн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх, эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа хүүхдийг аврах, хамгаалах зэрэг үйл ажиллагаанд чиглэж байгаа бөгөөд хүүхдийг зөв хүмүүжил төлөвшилтэй бие хүн болгох, бие бялдарыг хөгжүүлэх, авьяас чадварыг нь хөгжүүлэх чиглэлд дорвитой арга хэмжээ авахгүй, төсөв хөрөнгө зарцуулахгүй байна.

Мөн 6-18 хүртэлх насны хүүхдийн хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр бодлогын шинжтэй үйл ажиллагаа бодитоор хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоогүй бөгөөд боловсролын үйл ажиллагааны нэг төрөл болгон хууль тогтоомжид ерөнхий байдлаар тусгасан. Гэвч түүний хэрэгжилтийг хангах арга замыг тодорхой болгоогүй орхигдуулсан байна.

Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28.1 дэх хэсэгт “Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх тэдэнд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээг гэр бүл, хамт олонд нь түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, хүүхдийн хөгжлийн төвийг байгуулан, хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд тусгай хөтөлбөрийн дагуу үйлчилгээ үзүүлэхийг төрөөс” дэмжинэ гэж тусгасан. Гэсэн хэдий ч хичээлээс гадуурх үйл ажиллагаа явуулдаг сургалтын болон хөгжүүлэх төвүүдийн барилга байгууламж, орчин нөхцөл хүртээмжгүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт бага байсаар байна.

Эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад хүүхдийн хөгжлийг дэмжих тэр дундаа сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролоос гадуурх хөгжлийн үйл ажиллагаа/үйлчилгээг төрийн бодлогоор дэмжихэд шаардлагатай хууль эрх зүйн механизмыг тодорхой болгож өгөх нь зүйтэй байгаа тул “Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль” баталж, хүүхдийн хөгжилд чиглэсэн төрийн үүрэг, байгууллагын хариуцлага, санхүүжилтийн тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Нөгөөтэйгүүр өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль болон хүүхдэд зориулсан төсөв хөрөнгийн дийлэнх нь өнөөгийн нийгмийн ядуурал, нийгэмд гарч буй элдэв сөрөг үзэгдлээс үүдэн хүүхдийн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх, эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа хүүхдийг хамгаалах зэрэг үйл ажиллагаанд чиглэсэн байна.

Харин Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдээ хөгжил төлөвшлийн үед нь ирээдүйн хувь хүн болж өсөж хөгжих боломжийг төрийн бодлого болон санхүүжилтээр дэмжих эрх зүйн зохицуулалт орхигдож, хүүхдийг зөв хүмүүжил төлөвшилтэй бие хүн болгох, бие бялдарыг хөгжүүлэх, авьяас чадварыг нь хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэлд дорвитой арга хэмжээ авахгүй, төсөв хөрөнгө зарцуулахгүй байна.

Иймд тухайлсан хүүхдийн хөгжлийг дэмжих тэр дундаа хүүхдийн сонирхолд чиглэсэн хичээлээс гадуурх хөгжлийн үйл ажиллагаагаар ирээдүйн бие хүн болж

төлөвшихөд төрөөс үзүүлэх бодлогын дэмжлэгийг бие даасан хууль, санхүүжилт, хэрэгжилтийн механизмаар зохицуулах хэрэгцээ үүссэнийг судалгаан үр дүн, тоо баримтууд харуулсаар байна.

Хүүхдийн хөгжлийн чиглэлээр бие даасан хууль боловсруулж хууль тогтоомжийн шинэчлэлийг хийх шаардлагатай байна. Энэхүү шинэчлэл нь хүүхдийн авьяас чадвар, чөлөөт цаг, сэтгэлзүй, нийгэмшлийг дэмжих зорилгоор төрөөс хариуцлага хүлээхүйц зохицуулалт, хөрөнгө оруулалтын тогтолцоо бий болгож, боловсрол, соёл, спорт, нийгмийн хамгаалал зэрэг салбар хоорондын хамтын ажиллагаанд суурилсан нэгдсэн бодлогын шинэ орчин бүрдүүлэх, орон нутгийн төрийн захиргааны байгууллага болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Монгол Улс нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хуваарилах, хуримтлуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 4 дүгээр сарын 19-нд баталсан. Тус хуулийн хүрээнд Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжсөн сантай болсон. Уг хуульд Улсын Их Хуралд “Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан Хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг хэлэлцэн батлах” эрхийг олгосон. Тус зохицуулалтын хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих сургалт, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх механизмийг тодорхойлсон хууль тогтоомжийг баталж, түүнийг санхүүжүүлэх арга замыг Үндэсний баялгийн сангаас шийдвэрлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан анхдагч хуулийн төсөл болно.

Хуулийн төслөөр Монгол Улсын ирээдүй хойч үе болсон хүүхдүүд өөрийн хүсэл сонирхлын хүрээнд оюун ухаан, бие бялдар, авьяас чадвар, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих хөтөлбөр, сургалт, дугуйланд хамрагдан ирээдүйн бие хүн болж төлөвшихөд нь төрөөс бодлогын болон санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх чиглэл, хэлбэр, арга зам, хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн байгууллагуудын чиг үүрэг, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарчим, үүрэг хариуцлага, хяналтын тогтолцоотой холбогдогсон харилцааг зохицуулна.

Хуулийн төсөл нь дараах 5 бүлэгтэй байна. Үүнд:

- Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолтын тухай;
- Хоёрдугаар бүлэгт хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааны зохион байгуулалт буюу төрөөс хүүхдийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, чиглэл, хэлбэр, арга замын тухай;
- Гуравдугаарт бүлэгт төрийн байгууллага, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлно;
- Дөрөвдүгээр бүлэгт санхүүжилтийн эх үүсвэр, түүнийг зарцуулах журмын зохицуулалтыг тусгана;

- Тавдугаар бүлэгт хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих механизм, түүнийг хэрэгжүүлэх арга зам, хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хууль болон нэгдэн орсон олон улсын гэрээ болон үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх механизм бүрдэж, хүүхдийн хөгжлийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ. Мөн нөгөө талаар биеийн тамир, урлаг спорт болон олон төрлөөр өөрийгөө хөгжүүлэх нь хүүхдийг бие даасан хувь хүн болж төлөвших, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэж, улмаар хувь хүн болон нийгэм, эдийн засгийн хэмнэлт гаргах нөхцөл бүрдэх билээ. Хүүхэд чөлөөт цагаа үр ашигтай өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд зориулах тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгөтэй болж, хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, боловсрол сургалтын байгууллагын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн. Энэхүү анхдагч хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн болно.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай
хуулийн төслийн талаар

Нэг.Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг” болон “Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-нд хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор “Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана”, “Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ”, “Хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно”, “Сургууль бүрд спорт, урлагийн заал, номын сан бүхий хүүхдийн цогц хөгжлийн төвийг үе шаттайгаар байгуулна”, “Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлнэ”, “Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулна”, “Сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, хөгжил, хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэнэ”, “Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжих бодлого баримтална”, “Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ” гэж тодорхой заасан.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнө болон Ерөнхий боловсролын тухай хуулиар хүүхдийн эрх, хамгаалал, боловсрол, хүүхдийн хөгжлийг дэмжих зорилго, ерөнхий чиг үүрэг тусгасан хэдий ч хэрэгжилтийг хангах механизм дутмаг, тодорхойгүй байна.

Хүүхдийн оролцоонд суурилсан хөгжлийг дэмжих, нас насанд нь тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хөгжлийн ялгаатай байдал, олон янз байдлыг харгалзан үзэж тэгш хамруулах, үүнтэй уялдаатайгаар хот ба хөдөөгийн ялгааг арилгах, багш, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудал шийдэл хүлээж байгаа бөгөөд эдгээрийг салбарын бодлогоор бус салбар дундын, улсын хэмжээнд хэрэгжүүлэх нэгдсэн зохицуулалт бүхий хууль зүйн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа тул хүүхэд бүр хөгжлийн үйл явцад тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх, хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нийгмийн оролцоог

нэмэгдүүлэхэд чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагааг төрөөс дэмжих, санхүүжүүлэх, зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 5 бүлэг, 20 зүйлтэй бөгөөд дараах үндсэн зохицуулалтыг тусгасан. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн зорилго, хуулийн үйлчлэх хүрээ, хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд баримтлах зарчим, хуулийн нэр томъёоны тодорхойлолт зэргийг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт хүүхдийн хөгжлийг дэмжих ичээлээс гадуурх хөгжлийн чиглэлээрх сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт, чиглэл, хүүхдийн оролцоо, эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг, оролцоо зэрэг асуудлыг тусгана.

Гуравдугаар бүлэгт төрийн байгууллага болон оролцогчийн эрх, үүргийг тодорхойлно.

Дөрөвдүгээр бүлэгт хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг дараах эх үүсвэр, түүнийг зарцуулах журмын зохицуулалтыг заана.

Тавдугаар бүлэгт хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зэргийг тус тус тодорхойлно.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хууль болон нэгдэн орсон олон улсын гэрээ болон үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх механизм бүрдэж, хүүхдийн хөгжлийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Мөн нөгөө талаар биеийн тамир, урлаг спорт болон олон төрлөөр өөрийгөө хөгжүүлэх нь хүүхдийг бие даасан хувь хүн болж төлөвших, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэж, улмаар хувь хүн болон нийгэм, эдийн засгийн хэмнэлт гаргах нөхцөл бүрдэх билээ.

Хүүхэд чөлөөт цагаа үр ашигтай өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд зориулах тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгөтэй болж, хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, боловсрол сургалтын байгууллагын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

---oOo---

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг” болон “Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-нд хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор “Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана”, “Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ”, “Хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно”, “Сургууль бүрд спорт, урлагийн заал, номын сан бүхий хүүхдийн цогц хөгжлийн төвийг үе шаттайгаар байгуулна”, “Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлнэ”, “Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулна”, “Сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, хөгжил, хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэнэ”, “Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжих бодлого баримтална”, “Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ” гэж тодорхой заасан.

Дээрх Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүд болон холбогдох хууль тогтоомжид хүүхдийн хөгжлийн чиглэлээр зорилт, зохицуулалтууд байгаа боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй байна.

Аливаа зорилт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэд бүтэц, санхүүжилт, боловсон хүчний болон менежментийн нөөц хамгийн чухал ач холбогдолтой эдгээр асуудлыг шийдвэрлэхгүй бол Монгол улсын хойч ирээдүй болсон хүүхдийн хөгжлийн асуудал дорвитой ахиц гарахгүй тунхаглалын шинжтэй байна.

Түүнчлэн Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнө болон Ерөнхий боловсролын тухай хуулиар хүүхдийн эрх, хамгаалал, боловсрол, хүүхдийн

хөгжлийг дэмжих зорилго, ерөнхий чиг үүрэг тусгасан хэдий ч хэрэгжилтийг хангах механизм дутмаг, тодорхойгүй байна.

Хүүхдийн оролцоонд суурилсан хөгжлийг дэмжих, нас насанд нь тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хөгжлийн ялгаатай байдал, олон янз байдлыг харгалзан үзэж тэгш хамруулах, үүнтэй уялдаатайгаар хот ба хөдөөгийн ялгааг арилгах, багш, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудал шийдэл хүлээж байгаа бөгөөд эдгээрийг салбарын бодлогоор бус салбар дундын, улсын хэмжээнд хэрэгжүүлэх нэгдсэн зохицуулалт бүхий хууль зүйн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа тул Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай энэхүү хуулийн төслийг боловсруулж байна.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай энэхүү хуулийн төсөл нь хүүхэд бүр хөгжлийн үйл явцад тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх, хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагааг төрөөс дэмжих, санхүүжүүлэх, зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хуулийн төсөл нь 5 бүлэг, 20 зүйлтэй бөгөөд дараах үндсэн зохицуулалтыг тусгасан. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн зорилго, хуулийн үйлчлэх хүрээ, хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд баримтлах зарчим, хуулийн нэр томьёоны тодорхойлолт зэргийг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт хүүхдийн хөгжлийг дэмжих ичээлээс гадуурх хөгжлийн чиглэлээрх сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт, чиглэл, хүүхдийн оролцоо, эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг, оролцоо зэрэг асуудлыг тусгана.

Гуравдугаар бүлэгт төрийн байгууллага болон оролцогчийн эрх, үүргийг тодорхойлно.

Дөрөвдүгээр бүлэгт хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг дараах эх үүсвэр, түүнийг зарцуулах журмын зохицуулалтыг заана.

Тавдугаар бүлэгт хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зэргийг тус тус тодорхойлно.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хууль болон нэгдэн орсон олон улсын гэрээ болон үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх механизм бүрдэж, хүүхдийн хөгжлийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ. Мөн нөгөө талаар биеийн тамир, урлаг спорт болон олон төрлөөр өөрийгөө хөгжүүлэх нь хүүхдийг бие даасан хувь хүн болж төлөвших, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэж, улмаар хувь хүн болон нийгэм, эдийн засгийн хэмнэлт гаргах нөхцөл бүрдэх билээ. Хүүхэд чөлөөт цагаа үр ашигтай өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд зориулах тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгөтэй болж, хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, боловсрол сургалтын байгууллагын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль

тогтоомжид нийцсэн. Энэхүү анхдагч хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн болно.

-o0o-

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

/Анхдагч хууль/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь хүүхэд бүр хөгжлийн үйл явцад тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх, хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагааг төрөөс дэмжих, санхүүжүүлэх, зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хүүхдийн хөгжлийг дэмжих хууль тогтоомж

2.1.Хүүхдийн хөгжлийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Хүүхэд хамгааллын тухай хууль², Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль³, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль⁴ Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль⁵, Хүүхдийн эрхийн тухай хууль⁶, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүүхэд бүрийн хичээлээс гадуурх сургалтад хамрагдахтай холбогдсон үйл ажиллагаа, түүнд төр, орон нутгийн болон боловсрол, соёл, спорт, иргэний нийгмийн байгууллага, иргэн, хуулийн этгээд, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, эрх үүргийг зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хүүхдийн хөгжил” гэж хүүхэд өөрийн сонирхолд үндэслэн, өөрийгөө хөгжүүлэх зорилгоор хичээлийн хөтөлбөрөөс гадуур оролцох шинжлэх ухаан, технологи, гадаад хэл, нийгмийн оролцоо, спорт, соёл, урлагийн гэх мэт мэдлэг, ур чадварыг олгох, хувь хүний хөгжлийг дэмжих, сэтгэл зүйн боловсрол олгох дугуйлан, клуб, хөтөлбөр зэрэг бүтээлч үйл ажиллагааг;

4.1.2.“дэмжлэг” гэж төрөөс үзүүлэх санхүүжилт, дэд бүтэц, мэргэжилтний сургалт, чанарын хяналт зэрэг арга хэмжээг;

4.1.3.“Хүүхдийн хөгжлийн төв” гэж тухайн орон нутагт хүүхэд хичээлээс гадуурх буюу чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин, нөхцөл, санхүүжилтийг төрөөс зохион байгуулалттайгаар хангасан хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны чиглэл бүхий сургалтын үйл ажиллагаа явуулж буй байгууллагын барилга байгууламжийг;

4.1.4.“боловсролын сургалтын байгууллага” гэж Монгол Улсын газар нутагт төрийн болон хувийн өмчлөлийн хэлбэртэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, их, дээд сургууль зэрэг бүх шатны боловсролын үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагыг;

4.1.5.“хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагч” гэж хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааг гэрээний үндсэн эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5 дугаар зүйл.Хичээлээс гадуурх хөгжлийн чиглэлээрх сургалтын үйл ажиллагааны чиглэл

5.1.Дараах чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулна:

- 5.1.1.шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи
- 5.1.2.гадаад хэл
- 5.1.3.спорт, биеийн тамир
- 5.1.4.хөтөлбөрт суурилсан хувь хүний хөгжил
- 5.1.5.сэтгэл зүйн боловсрол
- 5.1.6.санхүүгийн боловсрол
- 5.1.7.нийгмийн оролцоо
- 5.1.8.хүрээлэн байгаа орчны боловсрол, байгаль хамгаалал
- 5.1.9.соёл, урлаг

5.2.Хичээлээс гадуурх хөгжлийн сургалтын үйл ажиллагаа нь хүүхэд бүрийн нас, сонирхол, хөгжлийн онцлогт нийцсэн байна.

5.3.Иргэний боловсролын агуулгад харшлах шашны шинжтэй үзэл санаа түгээх, улс төрийн болон ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлийн аливаа хэлбэрийг дэмжсэн агуулгатай үйл ажиллагааг хориглоно.

6 дугаар зүйл.Хүүхдийн оролцоо

6.1.Хүүхэд сайн дурын үндсэн өөрийн сонирхолд нийцсэн үйл ажиллагаанд оролцоно.

6.2.Хүүхдийн санал, санаачилгыг үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгана.

6.3.Хүүхэд өөрийн харьяалагдах ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Хүүхэд хөгжлийн төв, сургалтын төв, дугуйланд энэ хуулийн 5.1 дэх хэсэгт заасан чиглэлийн сургалтад жилд зургаан сараас доошгүй хугацаанд хамрагдаж болно.

7 дугаар зүйл.Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг, оролцоо

7.1.Хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч дараах байдлаар оролцоно:

7.1.1.эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийн оюун ухаан, сэтгэл зүй, бие бялдар, авьяас, ур чадвар, сонирхлын хөгжлийг дэмжих, хичээлээс гадуур өөрийгөө хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдах боломжийг хангах нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх;

7.1.2.хүүхдийн үзэл бодол, сонирхол, хэрэгцээг сонсож, шийдвэр гаргах үйл явцад оролцуулан, нас, онцлог, хөгжил, сонирхол, хэрэгцээнд нийцсэн байдлаар шийдвэр гаргах;

7.1.3.зөвшөөрөгдсөн хөгжлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийн талаарх мэдээллийг тогтмол авч, үнэлэлт дүгнэлт өгөх;

7.1.4.багш, хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагчтай харилцаж, хамтран ажиллах;

7.1.5.хөгжлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилт, хамрагдалтад хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд байгууллагад санал хүргүүлэх;

7.1.6.хөгжлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийн төлбөрт төсвөөс олгосон дүн хангалтгүй тохиолдолд зөрүүг сайн дурын үндсэн дээр гаргах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ОРОЛЦОГЧИЙН ЭРХ,ҮҮРЭГ

8 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

8.1.Улсын Их Хурал нь хүүхдийн хөгжлийг дэмжих талаар дараах бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1.улсын хэмжээнд хүүхдийн эрхийг хангах талаарх төрийн бодлогыг тодорхойлох;

8.1.2.улсын төсөв, Үндэсний баялгийн сангаас жил бүр хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтад зориулан олгох төсвийг батлах;

8.1.3.хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын үйл ажиллагаанд зарцуулах нийт санхүүжилтийн хэмжээг батлах;

8.1.4.хүүхдийн хөгжлийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих.

9 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх

9.1.Засгийн газар нь хүүхдийн хөгжлийг дэмжих талаар дараах бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.улсын хэмжээнд хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээрх бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангах;

9.1.2.хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

9.1.3.хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын болон Үндэсний баялгийн сангийн төсвийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулах;

9.1.4.хичээлээс гадуур хүүхдийн хөгжлийг дэмжихэд зориулан батлагдсан төсвийг хүүхдийн тоонд үндэслэн аймаг, нийслэлийн төсөвт шилжүүлэх.

10 дугаар зүйл.Хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

10.1.Хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүүхдийн хөгжлийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1.хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тайлагнах;

10.1.2.хүүхдийн асуудал хариуцсан бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

10.1.3.хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн цахим санг бүрдүүлэх.

11 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүрэг

11.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хүүхдийн хөгжлийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.1.тухайн шатны төсвөөс жил бүр хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтад зориулсан төсөв батлах;

11.1.2.энэ хуулийн 13.4-т заасан хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааг дэмжих бүтээн байгуулалт, дэд бүтэц, орчны тохируулга, шаардлагатай үед хэрэглэх материалаг нөөц, тоног төхөөрөмжийг зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх;

11.1.3.харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 13.1-д заасан хөгжлийн төвийг ажиллуулахад шаардлагатай төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжийг тэргүүн ээлжид ашиглуулах шийдвэрийг гаргах.

12 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг

12.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь хүүхдийн хөгжлийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1.харьяалах нутаг дэвсгэртээ Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

12.1.2.хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын үйл ажиллагаанд шаардагдах төсвийг орон нутгийн төсвийн төсөлд тусган тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

12.1.3.харьяалах нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаанд шаардлагатай барилга байгууламж, дэд бүтэц, орчны тохируулга, шаардлагатай үед хэрэглэх материалаг нөөц, тоног төхөөрөмжийн зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

12.1.4.хөгжлийн төвөөр очиж болон үйлчилгээ авах боломж нөхцөл нь хязгаарлагдсан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хичээлээс гадуур хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын үйл ажиллагааг хүртээмжтэйгээр зохион байгуулах;

12.1.5.энэ хуулийн 13.1-д заасан хөгжлийн төвийг харьяалах нутаг дэвсгэртээ байгуулахдаа тухайн орон нутгийн сургууль, цэцэрлэг, соёлын төв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн барилга байгууламжийг тэргүүн ээлжид гэрээгээр ашиглуулах;

12.1.6.төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтыг зохион байгуулах гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд⁷ нийцүүлэн сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;

12.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь 12.1.6-д заасан эрхийг сум, дүүргийн Засаг даргад шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

13 дугаар зүйл.Хүүхдийн хөгжлийн төвийн чиг үүрэг

13.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь тухайн орон нутгийн хүүхдийн тоо, нутаг дэвсгэрийн байршил, барилга байгууламжийн хүрэлцээ дээр тулгуурлан энэ хуулийн 5.1-д заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулах сургалт, дугуйлан зохион байгуулах хүүхдийн хөгжлийн төвийг төвлөрсөн болон төвлөрсөн бусаар байгуулна.

13.2.Хүүхэд хөгжлийн төвийг байгуулахдаа тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, соёлын төв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн барилга байгууламжийг тэргүүн ээлжид ашиглах бөгөөд хүүхэд бүрийн хэрэгцээ, шаардлага, онцлогт тохирсон ээлтэй, хүртээмжтэй байх нөхцөл боломжийг хангана.

13.3.Сонгон шалгаруулалтаар шалгарсан энэ хуулийн 5.1-д заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулах хувь хүн, хуулийн этгээд гэрээний үндсэн дээр хүүхдийн хөгжлийн төвд үйл ажиллагаа явуулж болно.

13.4.Энэ хуулийн 13.1-д заасан хувь хүн, хуулийн этгээд нь эрсдэлт нөхцөлд байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчилгээ үзүүлэх тусгайлсан хөтөлбөр, хүний нөөцтэй байх бөгөөд энэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

13.5 Иргэн, хуулийн этгээдийн шаардлага хангасан барилга байгууламжид гэрээний үндсэн дээр хүүхдийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг явуулж болно.

14 дүгээр зүйл.Боловсролын байгууллагын үүрэг

14.1.Бүх шатны боловсролын байгууллага нь үндсэн сургалтын цагаас бусад цагт тухайн сургуулийг хүүхэд хөгжлийн төвөөр ажиллуулах боломжоор хангана.

14.2.Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангана.

15 дугаар зүйл.Хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагчийн чиг үүрэг

15.1.Хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагч нь энэ хуулийн 5.1-д заасан хичээлээс гадуурх үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

15.2.Хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нартай хүүхдийг хөгжүүлэх, суралцуулах талаар хариуцлагын гэрээ байгуулж, эргэх холбоотой тогтмол харилцаж, санал хүсэлтийг хүлээн авч, тухай бүр шийдвэрлэн хамтран ажиллана.

15.3.Сургалт, дугуйланд хамрагдаж буй хүүхдүүдийг уралдаан, тэмцээн, хөгжлийн олон талт үйл ажиллагаанд оролцуулж, хүүхдүүдийн бүтээл, авьяас ур чадвар, амжилтыг эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтэд танилцуулж байна.

15.4.Хөгжлийн үйл ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнг сайжруулах чиглэлээр санал санаачилга гаргаж, төр, орон нутгийн холбогдох байгууллагууд, багш, эцэг эх, асран хамгаалагч нартай нээлттэй хамтран ажиллана.

15.5.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны гадна хүүхэд хамрагдахгүй байхаас урьдчилан сэргийлж хамтарсан багийн гишүүдтэй хамтран ажиллана.

15.6.Хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагч нь сар бүр сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн баримтыг холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулан баталгаажуулж, тухайн шатны Засаг даргын тамгын газарт хүргүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ САНХҮҮЖИЛТ

16 дугаар зүйл.Санхүүгийн эх үүсвэр

16.1.Хүүхдийн хөгжлийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

16.1.1.үндэсний баялгийн сангаас жил бүр олгох хөрөнгө;

16.1.2.улсын болон орон нутгийн төсөв

16.1.3.үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөр;

16.1.4.дотоод, гадаадын хуулийн этгээд болон олон улсын байгууллага, хувь хүнээс өгсөн хандив, тусламж.

17 дугаар зүйл.Хүүхдийн хөгжлийг санхүүжүүлэх зохицуулалт

17.1.Хичээлээс гадуурх хүүхэд хөгжүүлэх сургалтын үйл ажиллагааны зардал, дэд бүтэц, барилга байгууламж, тохируулга, шаардлагатай үед хэрэглэх материалаг нөөц, тоног төхөөрөмжийн санхүүжилт нь улсын төсөв, Үндэсний баялгийн сангаас жил бүр олгох хөрөнгө болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээс бүрдэнэ.

17.2.Хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтад хамрагдах хүүхдэд сар бүр төсвөөс олгох санхүүжилтийн дэмжлэгийн хэмжээг Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дах хэсэгт заасан Засгийн газрын гишүүд хамтран батална.

17.3.Хүүхдийн хөгжлийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагчийн санхүүжилтийг тухайн шатны Засаг дарга талуудын хооронд байгуулагдсан гэрээнд заасны дагуу сар бүр олгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

18 дугаар зүйл.Хуулийн биелэлтэд хяналт тавих

18.1.Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага, албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.

18.2.Тухайн шатны Засаг дарга болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн санд бүртгэлтэй хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулагч хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнг хүүхдийн оролцоо, чанар, хүртээмж, эцэг эхийн сэтгэл ханамжийн үндсэн дээр жил бүр дүгнэж жагсаалтыг шинэчилнэ.

18.3.Энэ хуулийн 18.2-д заасан үр дүнгийн үнэлгээний журмыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

19 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн болон зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд⁸ заасан хариуцлага хүлээлгэнэ.

19.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль⁹, Зөрчлийн тухай хуульд¹⁰ заасан хариуцлага хүлээлгэнэ.

19.3.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд торгуул оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

20 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

20.1.Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.1 дэх заалтын “Ирээдүйн өв сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор хуримтлуулах, хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар өнөөгийн үнэ цэнийг өсгөх, арвижуулах” гэсний дараа “хуримтлагдсан хүүгийн орлогын 50-аас доошгүй хувийг хүүхдийн хөгжилд зориулна.” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хүүхдийн хөгжлийг дэмжих хууль эрх зүйн орчныг сайжруулах төслийг боловсруулах төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хийж гүйцэтгэлээ.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид “Аргачлал” гэх/ 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт заасан хууль тогтоомжид хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2 дугаар зүйлийн 2.1-т заасан дараах үе шатаар хийсэн болно:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан судлах;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

Дээрх дарааллын дагуу нэгдүгээрт “Хүүхдийн хөгжлийг хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дэмжих” холбогдох ойлголт, харилцааг судалж, Монгол Улсын 6-18 насны хүүхдийн хөгжилд тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Үүний тулд Монгол Улсын болон бусад орны хууль тогтоомж, Олон улсын байгууллагаас гаргасан баримт бичиг, Олон улсын гэрээ, холбогдох ном сурах бичиг, өмнө нь хийгдсэн социологийн судалгаа, судалгааны тайлан, илтгэл, өгүүллийг уншиж судлах, харьцуулалт хийх болон бусад статистик мэдээллийг ашигласан бөгөөд асуудлын мөн чанар, түүний цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүдэд үүсэж буй асуудлын шалтгаан нөхцөлийг тус тус тодорхойлов.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1.Тодорхойлж шийдвэрлэх гэж буй асуудлын эрх зүйн зохицуулалт, мөн чанар, цар хүрээ

2024 оны байдлаар Монгол Улсын нийт хүн ам 3,544,835 болсон бөгөөд үүнээс 0-4 насны хүүхэд 340,277, 5-14 насны хүүхэд 756,524, 15-19 насны хүүхэд залуучууд 278,578 байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын нийт хүн амын 39 хувийг 19 хүртэлх насны хүүхэд залуучууд эзэлж байна.

Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцод 1990 онд нэгдэн орж соёрхон баталсан ч Хүүхдийн эрхийн тухай хуулийг 2016 онд баталж, Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2024 онд шинэчлэн найруулан баталсан бөгөөд эдгээр нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хамт хүүхдийн эрхийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенц нь ийнхүү Монгол Улсын хууль тогтоомжид тусгалаа олж хэрэгжиж байна. Мөн 2016 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд уг заалтуудыг тусган батлав. Эдгээр гурван хууль нь эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийн цогц хамгаалалт болно гэж зорьсон. Хүүхдийн эрхийн тухай хууль (2016) нь эрхийн талаарх өргөн хүрээний ойлголтыг тодорхойлж, үүрэг хүлээгчдийн хууль ёсны үүрэг хариуцлагыг голчлон хөндсөн бол Хүүхэд хамгааллын тухай хууль хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих зэрэг бүх хэлбэрийн хүчирхийллээс хүүхдийг хамгаалахад чиглэсэн болно.

Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн хөгжих эрхийг тодорхойлсон ч хангах, дэмжих зохицуулалт дутмаг, тунхагийн шинжтэй байсан бол 2024 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр хүүхдийн хөгжих эрхийг хангах чиглэлд хэд хэдэн зүйл, заалт нэмэгдсэн нь хөгжлийг дэмжих бодлогын суурь үндэслэл болох боломжтой байна. Тухайлбал, хүүхдийн эрхийн үндсэн зарчимд хоёр хэсэг нэмсэн нь хүүхдийн хөгжлийн тухай байна. Үүнд:

- Хүүхдийг бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүйн хувьд жигд хөгжих боломжийг хангах;
- Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ нь хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх зэрэг болно.

Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн хөгжих эрхийг дараах байдлаар тодорхойлсон. “Хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх” гээд энэ хүрээнд дараах долоон эрхийг тоочжээ. Үүнд:

- 1.Хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших;
- 2.Хүүхэд төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших;
- 3.Хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах;

- 4.Хүүхэд шашин шүтэх, эс шүтэх;
- 5.Хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах;
- 6.Хүүхэд гэр бүл, нийгмийн орчинд өөрийгөө хөгжүүлэх.
- 7.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамрагдах эрхтэй гэжээ.

Дээрхээс онцолбол “Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамрагдах” эрхийг 2024 оны нэмэлт өөрчлөлтөөр нэмсэн байна. Ийнхүү эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүрэг хүлээгч буюу төрд хүүхдийн хөгжлийг дэмжих тодорхой бодлогоор тодорхой үйлчилгээг үзүүлж, түүнд нь хүүхдүүд тэгш хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлэх үүргийг үүсгэсэн нь хүүхдийн хичээлээс гадуурх хөгжлийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалын суурь болно гэж үзэж байна.

Мөн “Хүүхэд хөгжих эрхээ амралт, чөлөөт цагаараа тоглож наадах, хүүхдийн зуслан, сувилалд амарч сувилуулах, өөрийн хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг, клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах зэрэг хэлбэрээр эдэлнэ” гэсэн нь төрийн хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хэлбэрүүдийг тодорхойлсон байна.

Тус хуулийн 2024 оны нэмэлт өөрчлөлтөөр хүүхдийн хөгжих эрхийг хангах, хөгжлийг дэмжих зохицуулалтыг сайжруулж, харьцангуй цогцоор зохицуулах эрмэлзэлтэй байсан нь бодлого стандартыг батлах, санхүүгийн хөшүүргийг бий болгох үүргийг Засгийн газарт оноосон зүйл заалтуудаас харагдаж байна. Үүнд:

- Эрүүл мэнд, спорт, боловсрол, соёл урлаг болон нийгмийн бусад үйлчилгээ нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн байна.
- Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллага үйлчилгээний бодлого, хөтөлбөртэй байх бөгөөд эрх бүхий этгээдээс баталсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллана.
- Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн, боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална гэсэн зэрэг болно.

Мөн хүүхдийн хөгжлийг шууд дэмжих нэгэн шинэ заалт нь тус хуулийн 13.1.10-т “Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж, батлуулах арга хэмжээ авах” гэж заасан нь болно.

Тус хуулийн 20 дугаар зүйл нь хүүхдийн эрхийн хэрэгжилтийн хяналтад чиглэсэн бол 20.4 дугаар зүйл заалтад хүүхдийн нэрийн өмнөөс хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх, сум, дүүргийн холбогдох этгээдийн хүүхдийн эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах эрх мэдэл, үүрэг хүлээсэн хүүхдийн эрхийн улсын байцаагчийг томилох тухай заасан. Эцэст нь ХЭК болон бусад олон улсын эрх зүйн баримт бичигт заасан Засгийн газрын чиг үүргийн дагуу хүүхдийн эрхийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хянах тухай Хүүхдийн эрхийн тухай хуульд заажээ.¹

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 2024 оны нэмэлт өөрчлөлт нь хүүхдийн хөгжих эрхийн концепцийг өргөжүүлж, тус эрхийн тэр дундаа сургуулийн өмнөх болон

¹ Хүүхэд хамгааллын тухай Монгол улсын хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан-2021

ерөнхий боловсролоос гадуурх хөгжлийн үйл ажиллагаа/үйлчилгээ болон үүнтэй холбоотой төрийн үүргийг тодорхойлж харьцангуй бодитой хэрэгжих үндэс суурийг тавьжээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь мөн л 2024 онд батлагдсан бөгөөд хуулийн зорилго нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад оршино гэжээ.

Тус хуульд зааснаар "Хүүхдийн сайн сайхан байдал" гэх ойлголтын салшгүй нэг хэсгийг "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчин нөхцөл" гэж тодорхойлж "Төр хүүхдийг хамгаалахдаа хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдлыг хангах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон арга хэмжээ авах" нь хүүхэд хамгааллын зарчим гэжээ (ХХТХ-ийн 4 ба 5 дугаар зүйлүүд).

Дээрх зарчмын дагуу хүүхэд хамгааллын тогтолцооны удирдлага, зохион байгуулалтыг голлон хэрэгжүүлэгч нь Засгийн газар байх бөгөөд "Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт хүүхдийн эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах талаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг тусгах, хүүхэд хамгааллыг тогтвортой санхүүжилтээр хангах үүрэгтэй" гэжээ. Тиймээс Засгийн газар нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчин нөхцөлийг бий болгох бодлогын арга хэмжээ авч, тогтвортой санхүүжилтээр хангах үүрэгтэй байна.

Гэр бүлийн тухай хуулийг 1999 онд баталсан бөгөөд тус хуулийн зорилго нь гэр бүлийн харилцаа, ялангуяа гэрлэлт, гэрлэлт дуусгавар болох, энэ үед гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа зохицуулахад чиглэгдсэн. Гэвч, тус хуулийн 5 дугаар бүлэг нь хүүхдийн үрчлэлт, асран хамгаалагч тогтоох зэрэг эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцааг зохицуулдаг. Энэ бүлэгт гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд нь гэрлэлтээ бүртгүүлсэн гэр бүлээс төрсөн хүүхдийн адил эрх эдлэх, гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн болон гэрлэгчдийн хэн нэгний нь дагавар хүүхдийг ялгаварлан гадуурхахыг хориглох тухай тус тус заасан.

Энэ хуульд мөн "Хүнд нөхцөл дэх хүүхэд" -ийн тухай заасан. Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахгүй бол сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгч томилох, түүнчлэн бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар хүүхдээ тэжээн тэтгэх боломжгүй, хорих газарт ял эдэлж байгаа хүний хүүхдийг сум, дүүргийн Засаг дарга хамгаална гэж заасан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуультай адил, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байгууллагын ажилтнууд хүүхдийн тухай мэдээлэх үүрэгтэй бөгөөд мэдээлэл авсан сум, дүүргийн Засаг дарга гурав хоногийн дотор эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдээ хамгаалах чадвартай эсэхийг тодорхойлох нөхцөл байдлын үнэлгээ хийх үүрэгтэй. Засаг даргад мөн 'хүүхдийг хүнд нөхцөл дэх хүүхэд' гэж бүртгэх эрх мэдэл байх бөгөөд хүүхдийг асран хамгаалах хүсэлт гаргасан иргэнд шилжүүлэх эсхүл тийм боломж байхгүй бол асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Түүнээс гадна Гэр бүлийн тухай хуулиар эцэг, эх байх эрхийг хязгаарлах, тодорхой тохиолдолд эцэг эх байх эрхээ алдахад хүргэх 'эцэг, эх байх эрхийг хасах' хүртэлх эрхийг шүүхэд олгодог. Ийм эцэг, эхийн хүүхдийг асран хүмүүжүүлэх, халамжийн байгууллагад шилжүүлнэ.

Сүүлийн 20 жилийн хугацаанд үйлчилж байсан **Боловсролын тухай хууль** 2002 онд батлагдаж байсан бол 2023 оны Боловсролын багц хууль шинэчлэгдэж Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Тус хуулиудаар хүүхдийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмших нас, сургалтын тогтолцоо, сургууль болон төрийн захиргааны байгууллага, орон нутгийн засаг захиргааны хүүхдэд боловсрол олгоход баримтлах бодлого, чиг үүрэг зэргийг тодорхойлж өгсөн.

Мөн тус хуулиар Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд орших бол Ерөнхий боловсролын зорилго нь суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино гэж боловсролын хүүхэд олгох мэдлэг боловсролыг тодорхойлсон.

Бодлогын баримт бичгүүдийн хувьд Монгол Улсын Засгийн газраас 1997 оны 1 сарын 22-ны өдрийн 30 дугаар тогтоолоор “Сурагч, өсвөр үеийнхний эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, 2013 оны 295 дугаар тогтоолоор “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөр, 2017 оны 9 сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр” /2017-2021/-ийг батлан хэрэгжүүлж байсан. Эдгээр нь хүүхдийн түлхүү боловсрол, хүүхдийн хамгаалалд чиглэсэн бөгөөд хэрэгжих хугацаанууд нь дуусгавар болсон байна.

Монгол Улсад 2024 оны байдлаар 264.8 мянган хүүхэд 1407 цэцэрлэгт, 797,9 мянган хүүхэд 885 Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бөгөөд үүнээс 1024 цэцэрлэг нь төрийн өмчийнх, 383 нь хувийн өмчийнх, ЕБС-ийн 705 нь төрийн өмчийнх бол 180 нь хувийн өмчийн сургууль үйл ажиллагаа явуулж байна.

Бүх шатны боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн болон техникийн боловсрол олгох чиглэлээр салбарт зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлж 2024 онд ДНБ-ий 5.7 хувьд хүргэлээ. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарт гүйцэтгэлийн үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрэн хэрэгжүүлж, 2024 онд боловсролын салбарт зарцуулах төсөв улсын төсвийн нийт зарлагын 13.7 хувьд хүрсэн бөгөөд Боловсролын салбарын төсвийн улсын нийт төсөвт эзлэх хувь 19.6 хувь болж өссөн.

Гэвч НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс /НҮБХХ/ жил бүр гаргадаг хүний хөгжлийн индексээр 2025 оны байдлаар дэлхийн 193 орноос 104-т жагсаж байна.²

Мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ/ OECD) 3 жил тутам Боловсролын олон улсын чанарын үнэлгээ- Programme for International Student Assessment (PISA) тайлангийн хамгийн сүүлийн буюу 2022 оны байдлаар 81 улсаас 51-т жагсаж байгаа³ нь манай улс хүний хөгжил, хүүхдүүдийн боловсролын үзүүлэлтээр дэлхийд дундажаас доогуур үзүүлэлттэй явж байна гэдэг нь харагдаж байна.

² Human development report 2025-UNDP

³ PISA report 2022

Мөн Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар 2020-2024 оны байдлаар хүүхэд оролцсон гэмт хэрэг 811-ээс 1373 болж нэмэгдсэн бол насанд хүрээгүй хүүхэд гэмт хэргийн хохирогч болсон үзүүлэлт 1101-ээс 2024 оны 10 сарын байдлаар 2413 болж нэмэгдсэн байна.

Энэ мэт насанд хүрээгүй хүүхэд гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн хохирогч болж байгаа нь нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлүүдээс шалтгааж байгаагаас гадна хүүхдийн хичээлээс гадуур өөрийгөө хөгжүүлэх, цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломж дутмаг байгаатай холбоотой юм.

Хүүхэд завтай, зорилгогүй, хяналтгүй үед өөрийгөө батлах, сониуч зангаа хангах, нөлөө бүхий бүлэгт багтах хүсэлтэй болдог. Энэ нь сөрөг бүлэглэл, хорт зуршил, гэмт хэрэг рүү татагдах үндэс болдог. НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF), НҮБХХ (UNDP) зэрэг байгууллагуудын тайлангуудаас харахад, чөлөөт цагийн аюулгүй, бүтээлч орчин дутмаг бүс нутагт хүүхдийн гэмт хэрэгт холбогдох, хохирогч болох үзэгдэл 2-3 дахин өндөр байгааг тогтоосон.

Монгол Улсад алслагдсан дүүрэг болон орон нутгийн түвшинд хүүхдэд зориулсан ногоон байгууламж, спортын талбай, чөлөөт цагаа өнгөрөөх төвүүд хомс байдаг. Сургуулийн хичээлийн бус цагаар хүүхдүүд хяналтгүй, хөндлөнгийн оролцоогүй нөхцөлд бүлэглэн гадуур сэлгүүцэх, цахим орчинд хорт агуулгад автах эрсдэл нэмэгддэг. Ялангуяа хүүхдийн хөгжлийн төвүүд хүрэлцээгүй, дугуйлангийн хамрагдалт бага байгаа нь хүүхдийн оролцоог сулруулж, зан үйлийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Энэхүү тандан судалгаа болоод хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн хүрээнд зорилтот бүлэг нь 6-18 насны хүүхэд байна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Учир нь Монгол Улс сургуулийн өмнөх насны буюу бага насны хүүхдийн цогц хөгжлийн бодлогыг тодорхойлсон бөгөөд арга зүй, тогтолцоо, механизмыг ялгаатай зохицуулах ёстой насны бүлгүүд юм. Энэ хүрээнд 2023 онд Боловсрол, шинжлэх ухаан, Эрүүл мэнд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалаар Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ (2023-2026) болон Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гэх баримт бодлогын баримт бичгүүдийг баталсан байна.

Тус бага насны хүүхдийн хөгжлийн бодлого нь хүүхэд бүр эрүүл, аз жаргалтай өсөж, хөгжих тэгш боломж, нөхцөлийг бүрдүүлж, тэдний ирээдүйн амьдралын чанарыг сайжруулахын тулд цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний үр ашигтай, нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх, Гэр бүл, олон нийтэд суурилсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг хөгжүүлэх, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, бага насны хүүхдийн цогц хөгжлийн салбар дундын мэдээллийн санд суурилсан хяналтыг бий болгох зорилготой байна.

6-18 хүртэлх насны хүүхдийн хөгжил, тэдгээрийг цаг заваа зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр тодорхой бодлогын шинжтэй үйл ажиллагаа бодитоор хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоогүй бөгөөд Боловсролын үйл ажиллагааны нэг төрөл болгон хууль тогтоомжид ерөнхий байдлаар тусгасан боловч түүнийг хэрэгжилтийг нь хангах арга замыг тодорхой болгоогүй орхигдуулсан байна.

Тухайлбал, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.10-т “Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг

байна.”, мөн хуулийн 20.16.”Энэ хуулийн 20.10-т заасан хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж тусгагасан.

Боловсролын чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байдлыг дурдвал Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 сарын 9-ний өдрий А/96 тушаалаар батлагдсан Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө/2021-2030/-нд “Монгол Улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан мэдлэгт суурилсан нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай иргэнийг цогцоор нь хөгжүүлэх” гэсэн зорилгыг дэвшүүлсэн. Хүн амын өсөлт, боловсролын үйлчилгээний тэгш хүртээмжтэй уялдуулан сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлж, нээлттэй боловсролын үйлчилгээний төрлийг өргөжүүлж, сургалтын тохируулгат орчныг бий болгох зорилготой байна.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 176 дугаар тогтоолоор баталсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд сургалтын хөтөлбөрийг боловсруулахад “Хамтын ажиллагаанд суурилсан байх - Суралцагч болон багшийг аюулгүй, таатай орчинд сурч хөгжих, ажиллах нөхцөлөөр хангах, сургалтын дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж, хэрэгсэл ашиглах боломжийг бүрдүүлэх, сургалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулахад төр, хувийн хэвшил, олон нийтийн оролцоог хангах” зарчмыг баримтална.

- Суралцагчийн хөгжлийг дэмжсэн сургалтаас гадуурх үйл ажиллагааг жишээ, удирдамжтайгаар санал болгосон байх;
- Суралцагч баяр баясгалантай, амар амгалан сурч хөгжих тэгш, хүртээмжтэй, аюулгүй орчныг төр, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоонд суурилж, бүрдүүлнэ;
- Суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн тоглоом наадгай, сургалтын материал, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлнэ гэжээ.

Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон төр, төрийн бус байгууллага, олон нийтийн түншлэлийг эрхэмлэнэ. Үүнд:

- Сургууль, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн хамтарч ажиллах боломжийг бий болгох, үүрэг, хариуцлага, дэмжлэгийг нэмэгдүүлнэ;
- Төр, төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцад оролцох нөхцөлийг бүрдүүлэх, идэвхтэй, бүтээлч хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ гэсэн зорилгыг тавьсан байна.

Мөн “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийг 2022 оны 8 сарын 17-ны өдрийн А/288 БСШУ-ны сайдын тушаалаар баталсан боловч зөвхөн сургууль дээр хэрэгжүүлэх байдлаар мөн хэт хайрцагласан нөхцөл байдалтай байна.

Дээр дурдсанчлан сургуулийн орчинд хүүхдийг хичээлээс гадуурх байдлаар хөгжих асуудлыг боловсролын хууль, бодлогын баримт бичигт тусгасан боловч түүний хэрэгжилтийг хангах зохицуулалт, механизмыг нь тодорхойгүй орхисон байна. Хэдийгээр сургалтын орчин болон багш нарт нь даалгасан боловч түүнийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байна. Учир нь мэргэжлийн багшийн хангалт 2023-2024 оны хичээлийн жилд 97.1 хувь болж өмнөх оны хичээлийн жилээс 1.3 пунктээр буурсан байна.

Мөн Ерөнхий боловсролын салбарт нэг багшид ногдох сурагчдын тоо дундажаар 2024 оны байдлаар хотод 23.3, хөдөө орон нутагт 19.4 болсон нь өмнөх онуудтай харьцуулахад нэмэгдэж байгаа үйл явц юм. Энэ нь багш нарын хувьд ажлын ачааллыг бий болгох, үүнээс үүдэн сурагчдыг хөгжүүлэх нэмэлт сургалтыг явуулах, ур чадвар, арга зүйгээ сайжруулах нөхцөл боломжийг хязгаарлаж байна.

Хүүхдүүд чөлөөт цагаа зөв, аюулгүй орчинд өнгөрөөх нөхцөлгүй байх нь тэднийг гэмт хэрэгт өртөх, оролцох эрсдэлд хүргэдэг. Иймээс хүүхдийн хөгжлийн орчныг тэлэх, дугуйлан, сургалт, соёл, спортын үйл ажиллагааг хүртээмжтэй, тогтвортой байлгах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогын үндэс суурь болдог төдийгүй хувь хүний хөгжил төлөвшилд чухал ач холбогдолтой юм.

Эцэг, эхчүүдийн үзэж буйгаар хичээлээс гадуурх үйл ажиллагаанд ихэнх тохиолдолд хүүхдийнхээ хүсэл, сонирхлыг нь нэн тэргүүнд харгалзан үздэг бөгөөд, мэдээж багшийн ур чадварыг судалж үздэг байна. Түүнчлэн спортын сонгон, секц, дугуйланд хамруулах сонирхолтой байдаг нь хүүхдийн төлөвшил, бие даах чадвар, хариуцлагатай бие хүн болж төлөвших боломжуудыг нээн хөгжүүлдэг гэж үздэгтэй холбоотой хэмээжээ.

Дугуйлан, сонгон, секц хичээллүүлж буй удирдлагын хувьд багш хувиараа хичээллүүлж байгаа сургалт, сонгонууд бол харьцангуй чанартай явагддаг гэж боддог байна. Учир нь тэнд тодорхой хэмжээний төлбөр авдаг, тэр утгаараа аль аль талдаа хариуцлагатай байдаг гэсэн судалгааны үр дүн гарсан бөгөөд энэ нь зөвхөн тухайн сургуулийн үндсэн үйл ажиллагаанд хамруулаад орхихгүй тодорхой санхүүжилтийг нь шийдвэрлэснээр илүү үр дүнтэй хэрэгжих нөхцөл боломж бүрдэх юм.

ҮСХ-ноос Монгол Улсын ядуурлын түвшний үзүүлэлтийг 2022 оны байдлаар 2024 онд танилцуулахад нийт хүн амын 27,1 хувьтай байгаа нь тэр бүр гэр бүлүүд хүүхдийнхээ хөгжилд санхүүжилт зарцуулах боломжгүй нөхцөл байдалтай байна.

Дээр дурдсанчлан төрийн зүгээс хүүхдийн суурь боловсрол болон хүүхдийн эрхийн хамгаалал чиглэлд төрийн бодлогын хэрэгжилтийг чиглүүлэхийн зэрэгцээ улс орны ирээдүй болсон хүүхдийн хөгжилд чиглэсэн тусгайлсан хууль эрх зүйн орчин бүрдүүлж бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь улс орны хөгжлийн чухал зорилгын нэг болоод байна.

Хүүхэд эрхээ хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, төсөв хөрөнгө гаргах талаар зохицуулалтуудыг тусгасан хэдий ч хэрэгжилт төдийлөн хангалтгүй байгаа бөгөөд хүүхдэд зориулсан төсөв хөрөнгийн дийлэнх нь өнөөгийн нийгмийн ядуурал, нийгэмд гарч буй элдэв сөрөг үзэгдлээс үүдэн хүүхдийн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх, эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа хүүхдийг аврах, хамгаалах зэрэг үйл ажиллагаанд чиглэж байгаа бөгөөд хүүхдийг зөв хүмүүжил төлөвшилтэй бие хүн болгох, бие бялдарыг хөгжүүлэх, авьяас чадварыг нь хөгжүүлэх чиглэлд дорвитой арга хэмжээ авахгүй, төсөв хөрөнгө зарцуулахгүй байна.

Хүүхдийн хөгжлийн чиглэлээр бие даасан хууль боловсруулж хууль тогтоомжийн шинэчлэлийг хийх шаардлагатай байна. Энэхүү шинэчлэл нь хүүхдийн авьяас чадвар, чөлөөт цаг, сэтгэлзүй, нийгэмшлийг дэмжих зорилгоор төрөөс хариуцлага хүлээхүйц зохицуулалт, хөрөнгө оруулалтын тогтолцоо бий болгож, боловсрол, соёл, спорт, нийгмийн хамгаалал зэрэг салбар хоорондын хамтын ажиллагаанд суурилсан нэгдсэн бодлогын шинэ орчин бүрдүүлэх, орон нутгийн төрийн захиргааны байгууллага болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлэхэд чиглэнэ.

ХОЁР.АСУУДАЛ ҮҮССЭН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Монгол Улсад Хүүхдийн хөгжлийн бие даасан бодлого, хууль тогтоомжуудийн хэрэгжилт хүүхдийн хөгжлийн чиглэлээр хэрэгжихгүй байгаа нь төрийн бодлогын, зохион байгуулалтын, санхүүгийн, болон хууль эрх зүйн хүрээний олон хүчин зүйлтэй холбоотой.

Нэгдүгээрт, өнөөг хүртэл Монгол Улс Хүүхдийн хөгжлийн бие даасан бодлого боловсруулж хэрэгжүүлээгүй бөгөөд боловсрол, соёл, спорт, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд гэх мэт олон салбарт тус асуудлыг харъяалуулдаг боловч Монгол Улс монгол хүнээ бэлтгэх боловсруулах чиглэлээр бие даасан бодлого, уялдаатай төлөвлөлт дутмаг байна. Мөн дээрх салбар хоорондын хариуцлага тодорхойгүй, харилцан уялдаагүйгээс хэрэгжилт саардаг.

Хоёрдугаарт, санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр байхгүй байна. Тухайлбал хүүхдийн хөгжлийн чиглэлээр тогтмол хөрөнгө оруулалт хийх тогтолцоо байхгүй. Орон нутаг, сургуулиудад хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөгжлийн дугуйлан, чөлөөт цагийн орчин бүрдүүлэх хөрөнгө мөнгө хангалтгүй. Хандив, төсөл хөтөлбөрөөс хамааралтай учир тогтвортой бус, урт хугацаанд хэрэгжихгүй байна.

Гуравдугаарт, Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, боловсролын чиглэлээр хууль тогтоомжууд байгаа боловч эдгээр нь түлхүү хүүхдийн эрх, зөрчигдсөн эрх нь хамгаалагдах чиглэлээрх зохицуулалтыг агуулдаг. Эдгээр хууль тогтоомжид хүүхдийн хөгжлийн асуудлыг хангалттай тусгаагүй, тунхагийн шинжтэй тусгаж түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоогүйгээс хүүхдийн хөгжлийн чиглэлээр төрийн байгууллага бодитой ажиллах хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна. Мөн орон нутгийн түвшинд хүүхдийн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, чиг үүрэг тодорхойгүй байна.

Дөрөвдүгээрт, Хүүхдийн хөгжлийн чиглэлээр ажиллах мэргэжлийн боловсон хүчин хомс, ялангуяа орон нутагт сургууль, цэцэрлэгийн багш нарын ажлын ачаалал өндөр, нэмэлт хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулах боломжгүй, сургалтын хөтөлбөр, арга зүй шинэчлэгдээгүй, орчин үеийн хүүхдүүдийн хэрэгцээг шаардлага сонирхлыг хангахгүй байна. Мөн санхүүжилтийн хөшүүрэг байхгүйгээс хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр боловсон хүчин бэлтгэгдэх, чадавхжуулах боломж бүрдэхгүй байна.

Тавдугаарт, Хүүхдийн хөгжилд чиглэсэн хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүд бүрдээгүй. Хууль, бодлогын хэрэгжилтэд төрийн болон олон нийтийн хяналт сул, мэдээллийн ил тод байдал хангалтгүй буюу хууль тогтоомж бодлогын хэрэгжилтийн хяналт үнэлгээний механизм сул байна.

Төгсгөлд нь дурдахад Монгол Улс ирээдүй хойч үе төдийгүй одоо үеийг тодорхойлох хүүхдүүд рүү чиглэсэн бодлого, хууль тогтоомжийг боловсруулах,

хэрэгжүүлэхдээ хүүхдүүдийн санаа бодлогыг тусгах тогтолцоо сул байна. Хүүхдийг “**хамгаалах**” субъект гэж хардаг хандлага давамгайлж, хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэхдээ хүүхдүүдийн санаа бодлогыг тусгах тогтолцоо сул байна. Хүүхдийг “**хамгаалах**” субъект гэж хардаг хандлага давамгайлж, холбоотой гэж үзэж байна.

ГУРАВ.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ

Монгол Улсад Хүүхдийн хөгжлийг дэмжих үр дүнтэй бие даасан тогтолцоог бий болгохын тулд хүүхдийн танин мэдэхүй, сэтгэл зүй, бие бялдар, авьяас, нийгмийн ур чадварын тэнцвэртэй хөгжилд чиглэсэн дараах зорилгуудыг тавьж ажиллах нь зүйтэй байна.

Зорилт 1.Хүүхдийн хөгжлийг дэмжих бие даасан хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнө болон Ерөнхий боловсролын тухай хуулиар хүүхдийн эрх, хамгаалал, боловсрол, хүүхдийн хөгжлийг дэмжих зорилго, ерөнхий чиг үүрэг туссан ч хэрэгжилтийг хангах механизм дутмаг, тодорхойгүй байна.

Хүүхдийн оролцоонд суурилсан хөгжлийг дэмжих, нас насанд нь тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хөгжлийн ялгаатай байдал, олон янз байдлыг харгалзан үзэж тэгш хамруулах, үүнтэй уялдаатайгаар хот ба хөдөөгийн ялгааг арилгах, багш, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудал шийдэл хүлээж байгаа бөгөөд эдгээрийг салбарын бодлогоор бус салбар дундын, улс орон даяар хэрэгжих хууль зүйн цогц зохицуулалтаар шийдвэрлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг” болон “Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-нд хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор “Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана”, “Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ”, “Хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно”, “Сургууль бүрд спорт, урлагийн заал, номын сан бүхий хүүхдийн цогц хөгжлийн төвийг үе шаттайгаар байгуулна”, “Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлнэ”, “Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулна”, “Сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, хөгжил,

хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэнэ”, “Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжих бодлого баримтална”, “Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ” гэж тодорхой тусгасан.

Эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад хүүхдийн хөгжлийг дэмжих тэр дундаа сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролоос гадуурх хөгжлийн үйл ажиллагаа/үйлчилгээг төрийн бодлогоор дэмжихэд шаардлагатай хууль эрх зүйн механизмыг тодорхой болгож өгөх нь зүйтэй байгаа тул “Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль” баталж, хүүхдийн хөгжилд чиглэсэн төрийн үүрэг, байгууллагын хариуцлага, санхүүжилтийн тогтолцоог хуульчилна. Одоогийн “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай”, “Боловсролын тухай”, “Нийгмийн хамгааллын тухай” хуулиудад уялдаа холбоотой нэмэлт оруулна.

Зорилт 2.Хүүхдийн хөгжлийг дэмжихэд төрөөс баримтлах бодлого хэрэгжилтийн механизм, санхүүжилтийг тогтолцоог сайжруулах.

Дээр дурдсанчлан Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүд болон холбогдох хууль тогтоомжид хүүхдийн хөгжлийн чиглэлээр зорилт, зохицуулалтууд байгаа боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй орхигдсон байна.

Аливаа зорилт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэд бүтэц, санхүүжилт, боловсон хүчний болон менежментийн нөөц хамгийн чухал ач холбогдолтой эдгээр асуудлыг шийдвэрлэхгүй бол монгол улсын хойч ирээдүй болсон хүүхдийн хөгжлийн асуудал дорвитой ахиц гарахгүй тунхаглалын шинжтэй болж үлдэнэ.

Монгол Улс нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хуваарилах, хуримтлуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 4 сарын 19-нд баталсан. Тус хуулийн хүрээнд Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжсөн сантай байх бөгөөд үйл ажиллагааны зарчим нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тулгуурласан байхаар тусгасан.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд Улсын Их хуралд “Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан Хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг хэлэлцэн батлах” эрхийг олгосон тул тус зохицуулалтын хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих сургалт, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх механизмийг тодорхойлсон хууль тогтоомжийг баталж, түүнийг санхүүжүүлэх арга замыг Баялгийн сангаас шийдвэрлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.

Хичээлээс гадуурх хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүдийг дэмжихэд барилга байгууламж, тоног төхөөрөмжийн дэд бүтцийг төрөөс нэгдсэн бодлогоор дэмжихээс гадна тогтмол үйл ажиллагаа явуулахад хамгийн том дэмжлэг нь сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх явдал юм.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.1.2-т заасны дагуу Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд

тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх зорилготой тул хүүхдүүдийн хөгжих эрхийг хангах сургалтын төлбөрийг төрөөс дэмжих боломж бүрдэж байна.

2024 оны байдлаар Улаанбаатар хотод англи хэлний сургалтын төлбөр дундажаар 1 сарын 200-250 мянган төгрөг, бүжгийн сургалт, сагсны сургалт дундажаар 1 сарын 80-100 мянган төгрөг, хөдөө орон нутагт 1 сарын 100-150 мянган төгрөг, бүжгийн сургалт, сагсны сургалт дундажаар 1 сарын 50-80 мянган төгрөг байна.

Монгол Улсад 6-16 насны 800 мянга орчим хүүхэд байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн 1 сарын хичээлээс гадуурх сургалтын зардлыг дундажаар 50,000 төгрөг байхаар төлөвлөж 6 сарын хугацаанд хамрагдах төсөвт өртгийн 300,000 төгрөгийг төрийн зүгээс дэмжлэг үзүүлж Хуримтлалын сангаас гаргаж, үлдсэн хэсгийг эцэг, эх, асран хамгаалагч нар нь гаргах байдлаар сургалтын төлбөрийн санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой юм. Ингэснээр жилдээ 240 орчим тэрбум төгрөгийг Ирээдүйн өв сан болон Хуримтлалын сангаас зарцуулах шаардлага гарна.

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд зааснаар 507 орчим тэрбум төгрөг байхаар тусгасан байна. Энэ нь 5-18 насны хүүхэд Монголын нийт хүний амын 30 орчим хувийн эзэлж байгаа тул Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан газрын хэвлийн баялгийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх гэсэнтэй нийцэх юм.

Сургалтын төв, хөгжлийн төвүүдийг барилга байгууламж, дэд бүтцийг Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” нийцүүлэн шийдвэрлэх боломжтой.

Учир нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологийг дэмжсэн байхыг шаарддаг тул тухай орон нутгийн хөгжлийн сангаас тухайн жилд хэрэгжүүлэх хүүхдийн хөгжлийг дэмжих барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг зардлыг тодорхой тусгаж өгөхийг хуулиар зохицуулна.

2021 онд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд Хүүхдийн төлөө санг нэмсэн бөгөөд тус сан нь Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын хөрөнгөд, олон улсын уралдаан, тэмцээнд оролцон тэргүүн байр эзэлж, амжилт үзүүлсэн хүүхдүүдийг урамшуулахад, олон улсын тэмцээнд оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжихэд зарцуулагддаг тул тус сангаас тодорхой хэсэг барилга, байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дэмжих боломжтой юм. Хүүхдийн төлөө санд 2024 оны байдлаар 14 тэрбум төгрөг хуримтлагдсан байна.

Зорилт 3.Хүүхдийн хөгжлийг дэмжих тогтолцоог төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны түншлэл дээр тулгуурлан хэрэгжүүлнэ.

Хүүхдийн хөгжлийг дэмжих нь урт хугацааны тогтвортой үйл ажиллагааг шаардаж байгаа бөгөөд өнөөдийн байдлаар Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхдийг хамгаалах тухай хууль болон Боловсролын хууль тогтоомжид тодорхой зорилго зорилтуудыг тусгасан боловч бодитой, үр дүнтэй хэрэгжилтгүй байгаагийн нэг шалтгаан нь санхүүжилтийн механизм ба тухайн үйл ажиллагааны менежменттэй шууд холбоотой. Дээр дурдсан хууль тогтоомжид хүүхдийн хөгжил, хүүхэд хамгаалал, хичээлээс гадуурх үйл ажиллагааг төрийн байгууллагын нэг дайвар чиг үүрэг болгон оруулж, хэрэгжилтийг нь хангуулах зохицуулалт хийсэн нь тус хөтөлбөрүүд бодитой хэрэгжихгүй байгаагийн нэг шалтгаан юм.

Хүүхдийн хөгжлийг дэмжих гол дэмжлэг нь хичээлээс гадуур сургалтын хэлбэр тул түүнийг хэрэгжүүлэх чиг үүргийг төрийн захиргааны байгууллагын нэг чиг, үүрэг, эсхүл сургуулийн нэмэлт үйл ажиллагаа болгож орхихгүйгээр хувийн хэвшил бие даан хэрэгжүүлж, дэд бүтэц, санхүүжилтийн хүрээнд л төрийн бодлогоор дэмжих арга замыг хуулийн зохицуулалтаар тодорхойлно.

Монгол Улс Төр хувийн хэвшлийн тухай хуулийг 2022 онд баталсан бөгөөд тус хуулийн гол зорилго нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшил эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хэрэгжүүлэх юм. Иймд хүүхдийн хөгжлийг дэмжих сургалт, клубын дэд бүтцийг төр хувийн хэвшлийн хүрээнд бүтээн байгуулах, менежментийг нь хувийн хэвшлээр хийлгэх хууль эрх зүйн орчин аль хэдийн бүрдсэн байна.

ДӨРӨВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу хоёрдугаар хэсэгт заасан зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар (ямар нэгэн арга хэмжээ авахгүй, одоогийн байдал хэвээр байх)	Хүүхдийн хөгжлийг дэмжих механизмын үр нөлөөгүй, тодорхойгүй байдал хэвээр үргэлжилнэ. Хүүхэд хичээлээс гадуур, өөрийн хүсэл сонирхлынхоо хүрээнд хөгжих боломжийг дэмжихэд тулгамдаад байгаа бодлогын болон санхүүгийн дэмжлэгийн асуудлууд шийдвэрлэгдэхгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч Монгол Улсын ирээдүй хойч болсон хүүхдийн хөгжлийн асуудлууд шийдвэрлэгдэхгүй хэвээр байна.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Нийтэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах, сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн цахим сүлжээ ашиглах, гарын авлага, мэдээллийн хуудас гаргах зэрэг нь хүүхдийн хөгжлийн чиглэлээр тулгамдаад байгаа бодлогын асуудлыг шийдвэрлэхгүй тул энэ хувилбар зорилгод хүрэх арга болж чадахгүй юм.	Тодорхой хэмжээний зардал гарна. Тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Үр дүн сөрөг
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Хүүхдийн хөгжил нь улс орны хөгжилд хамгийн чухал үүрэгтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулинд хүүхдийн ашиг сонирхлыг төрөөс хамгаална гэсэн байгаа. Хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр төрөөс	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг арилгаж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй

		бодлогоор дэмжихгүй бол тус асуудал нь зах зээлийн механизмаар шууд шийдэгдэх боломжгүй юм. Зах зээлийн механизмаар буюу татвар, хураамжийн бодлого, лиценз зөвшөөрөл болон квот зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс илүү хууль эрх зүйн хүрээний зохицуулалтыг шийдэх шаардлагыг харуулж байгаа.		
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Хүүхдийн хөгжлийн чиглэлийн бие даасан бодлого байхгүй, тус чиглэлээр хэрэгжүүлж байгаа тодорхой хөтөлбөрүүдийн хэрэгжилт муу байгаа нь санхүүжилтийн механизм тодорхойгүй байгаатай холбоотой. Тиймээс төрөөс тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Тус дэмжлэгийг Үндэсний баялагын сан болон холбогдох сангуудаас шийдвэрлэх боломжтой юм.	Тодорхой хэмжээний зардал гарна	Тодорхой үр дүнгүүд гарна.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, сургалтыг Ерөнхий боловсролын сургалтын нэг чиг үүрэгт оруулаад орхисон, хэрэгжилтийн механизм, санхүүжилтийг нь тодорхойлоогүйгээс төрийн бус байгууллага, хувийн хэвшил тус үйл ажиллагаанд хэрхэн оролцох хууль зүйн зохицуулалт нь	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй. Мөн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болно.	Шууд үр дүн гарахгүй.

		хангалттай бус байна.		
6	Захиргааны шийдвэр гаргах	Хүүхдийн хөгжлийг дэмжихэд тулгамдаад байгаа асуудал нь санхүүжилт, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон хууль тогтоомжийн зохицуулалт хангалтгүй байгаатай холбоотой. Энэ санхүүжилтийг зөвхөн нэг яам эсхүл төрийн захиргааны байгууллагад олгогдсон төсвийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй бөгөөд ирээдүй хойч үеийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх санхүүжилт болон үйл ажиллагааны төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны шинэ механизмыг бий болгох шаардлагатай байгаа тул зөвхөн захиргааны акт, хэм хэмжээний акт гаргах замаар шийдвэрлэх боломжгүй бөгөөд хэд хэдэн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Зорилгод нийцсэн үр дүнд хүрэх боломжгүй
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаагаар тэдний хүсэл сонирхлыг нь дэмжиж, цагийг үр дүнтэй зөв өнгөрүүлэх боломжийг улс орон даяар тэгш хүртээмжтэй хүргэх тогтолцоог бий болгохын тул санхүүжилтийн дэмжлэгийн шинэ механизмийг бий болгох, түүнийг хэрэгжилтийг нь төрд үлдээх бус хувийн	Зардал гарах боловч энэ нь асуудлуудыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ	Үр дүнтэй

	хэвшлийн ажиллагаан тулгуурлах зохицуулалтыг тогтоомжийн хийх замаар шийдвэрлэж зорилгодоо боломжтой юм.	үйл дээр хууль шинэчлэл		
--	---	----------------------------------	--	--

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна. Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна” гэсний дагуу Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хууль болон түүнийг дагалдан гарах Үндэсний баялгийн санд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна. Мөн цаашид түүнтэй нийцүүлэн дээрх хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага бий болно.

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Сонгосон хувилбар /хуулийн төсөл/ -ын үр нөлөөг Аргачлалын 6.2-т заасан ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хавсралтаас үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл нь хүний эрхийг хууль бусаар хязгаарлах, ялгаварлан гадуурхах зэрэг хүний эрхийн зөрчлийг агуулаагүй, харин Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 7-д “Сурч боловсрох эрхтэй” болон 11-д “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасныг хангахад шууд чиглэгдэж байна. Түүнчлэн Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн хуульчилсныг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл нь иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт зардал үүсгэхгүй юм. Хуулийн төсөл батлагдсанаар биеийн тамир, урлаг спорт болон олон төрлөөр

өөрийгөө хөгжүүлэх нь хүүхдийг бие даасан хувь хүн болж төлөвших, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэж, улмаар хувь хүн болон нийгэм, эдийн засгийн хэмнэлт гаргах нөхцөл бүрдэх билээ. Хүүхэд чөлөөт цагаа үр ашигтай өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд зориулах тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгөтэй болж, хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, боловсрол сургалтын байгууллагын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөлд туссан зохицуулалт нь нийгэмд эерэгээр нөлөөлнө. Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх механизм бүрдэж, хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Хуулийн төслийн нэмэлт өөрчлөлтөөр хүүхдийн хөгжлийг дэмжих сургалт, дугуйлангийн төлбөрийг Үндэсний баялгийн сангаас шийдвэрлэх, үйл ажиллагааны менежментийг хувийн хэвшил хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдэнэ. Ингэснээр улсын хэмжээнд бүхий л хүүхдүүд хичээлээс гадуурх хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдан өөрийнхөө сонирхсон чиглэлээр хөгжих боломж бүрдэнэ. Хүүхдүүд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бүрдсэнээр насанд хүрээгүй хүний холбогдох гэмт хэргийн тоо буурна.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

ЗУРГАА.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ДҮГНЭЛТ

Судалгааны явцад хуулийн төсөл боловсруулах нь хүүхдийн хөгжлийг дэмжих бие даасан хууль бий болгож, хүүхдийн хөгжлийн чиглэлээр гаргасан бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн зогсонги байдлыг арилгах, түүнчлэн эрх зүйн болон практик хэрэгжилтийн хүрээнд тогтвортой байдлыг хангах боломжтой үр нөлөөний хувьд давуу хэмээн дүгнэсэн билээ.

Монгол Улсад ойролцоогоор 6-18 насны 1 сая орчим хүүхэд байгаа бөгөөд тэдгээрийн 797,9 мянган хүүхэд нь 885 ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна.

2019 оны байдлаар Монгол Улсад нийт 593,200 сурагч байснаас 117,453 буюу 19,7 хувь нь хичээлээс гадуурх сургалт, хөгжлийн төвд хамрагдаж байсан байна. Эдгээрийн 30 орчим хувь нь Улаанбаатар хотод хамрагдаж байгаа үзүүлэлттэй байгаа бөгөөд бусад хэсэг нь 21 аймагт хуваагдсан нь хөдөө орон нутагт хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдах боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Тиймээс хүүхдийн хөгжлийг дэмжих бие даасан эрх зүйн орчныг сайжруулах хууль эрх зүйн бодит дэмжлэгийг үзүүлэх байдлаар хууль зүйн шинэчлэл хийх нь тулгамдаад байгаа олон сөрөг үр дагаварыг бууруулж, нийгэм эдийн засгийн хувьд чухал ач холбогдолтой үр дүн гарна гэж үзэж байна.

ДОЛОО.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Олон улсын туршлагаудыг харьцуулсан байдал

Олон улсын туршлагаудыг НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО), Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын тайлангууд болон улс орнуудын мэдээлэлд үндэслэн боловсруулсан болно.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ/ OECD) 3 жил тутам Боловсролын олон улсын чанарын үнэлгээ- Programme for International Student Assessment (PISA) тайлан гаргадаг бөгөөд боловсролын чанар, түвшинг өргөн хүрээнд дата мэдээлэлтэй үнэлдэг байна. Хамгийн сүүлд хийгдсэн тайлан нь 2022 оны байдлаар (2000 оноос хийгдэж эхэлсэн) бөгөөд энэ удаагийн тайланд математик, уран зохиол болон шинжлэн ухааны мэдлэгийг үнэлэхээс гадна бүтээлч байдалд анхаарсан байна. Тус үнэлгээнд 81 улсын 700,000 сурагчид хамрагдсан байна. Энэхүү үнэлгээ нь сурагчдын хэр сайн нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэж чадаж байгаа, шүүмжлэлт сэтгэлгээтэй байгаа, мөн үр дүнтэй харилцаж чадаж байгаа эсэхийг үнэлдэг. Энэ нь боловсролын тогтолцоо нь сурагчдыг амьдралын сорилт болон ирээдүйн амжилтад хэр сайн бэлтгэж байгааг ойлгож, дүн шинжилгээ хийхэд тусалдаг.



Хүснэгт. Улс орнуудыг боловсролын чанараар харьцуулсан байдал

№	Улс/ Эдийн засаг	Математик	Уран зохиол	Шинжлэх ухаан	Дундаж үзүүлэлт
	OECD-ийн дундаж	472	476	485	478
1	Сингапур	575	543	561	560
2	Макао (БНХАУ)	552	510	543	535
3	Япон	536	516	547	533
4	Тайвань (БНХАУ)	547	515	537	533
5	Өмнөд Солонгос	527	515	528	523
6	Хонг Конг (БНХАУ)	540	500	520	520
7	Эстони	510	511	526	516
8	Канад	497	507	515	506
9	Ирланд	492	516	504	504
10	Швейцарь	508	483	503	498
11	Австрали	487	498	507	497
12	Финлянд	484	490	511	495
13	Шинэ Зеланд	479	501	504	495
14	Их Британи	489	494	500	494
15	Польш	489	489	499	492
16	Чех	487	489	498	491
17	Дани	489	489	494	491
19	Швед	475	496	499	490
33	Норвеги	468	477	478	474
51	Казахстан	425	386	423	411
53	Монгол Улс	425	378	412	405

Эх сурвалж: ЭЗХАХБ, 2022 оны PISA тайлан

OECD-ийн дунджаас 18 улс 3 үзүүлэлт тус бүрээр дээгүүр үнэлгээтэй байгаа бөгөөд Монгол Улс дунджаас доогуур үнэлгээтэй байна. Казахстан улс 2018 оны үзүүлэлтээс өссөн үзүүлэлтэй байна (математикаар 2018 онд 54-т жагссан бол 2022 онд 47-д, уран зохиолоор 2018 онд 61-т жагссан бол 2022 онд 61-д, ШУ-наар 2018 онд 69-т жагссан бол 2022 онд 49-д жагссан байна).

Үүнээс өндөр үзүүлэлттэй болон үндэсний баялгийн сантай зэрэг шалгуураар сонгон Сингапур, Эстони, Норвеги, Казакстан зэрэг улсыг нарийвчлан судлав. Мөн хувийн хэвшилтэй хамтын ажиллагааг дэмжих эрх зүйн орчин бүрдсэн байдлыг харгалзан тусгав.

2023 онд Хүний хөгжлийн индексээр Монгол Улс улс 193 улсаас 104-т жагссан байна.

Улсын код	Улс	Байр	Үзүүлэлт	Улсын код	Улс	Байр	Үзүүлэлт
ISL	Исланд	1	0.972	GBR	Их Британи	13	0.946
CHE	Швейцарь	2	0.97	SGP	Сингапур	13	0.946
NOR	Норвеги	2	0.97	ARE	АНЭ улс	15	0.94
DNK	Дани	4	0.962	CAN	Канад	16	0.939
DEU	Герман	5	0.959	LIE	Лихтенштейн	17	0.938
SWE	Швед	5	0.959	NZL	Шинэ Зеланд	17	0.938

AUS	Австрали	7	0.958	USA	АНУ	17	0.938
HKG	ХонгКонг (Хятад)	8	0.955	KOR	БНСУ	20	0.937
NLD	Голланд	8	0.955	EST	Эстони	36	0.905
BEL	Бельги	10	0.951	KAZ	Казакстан	60	0.837
IRL	Ирланд	11	0.949	MNG	Монгол	104	0.747
FIN	Финлянд	12	0.948				

Эх сурвалж: <https://hdr.undp.org/data-center/documentation-and-downloads>

Сингапур ХХИ- 13 (2023)

Сингапур нь цогц боловсролыг онцгойлон чухалчилдаг бөгөөд хичээлээс гадуурх хөгжлийн үйл ажиллагаа (Co-curricular activities)-г сургуулиудад заавал хэрэгжүүлдэг. Боловсролын цогц хөгжилд төрөөс ихээхэн хөрөнгө оруулдаг. 2022 онд ДНБ-ийхээ 2.49 хувийг, 2023 онд 2.19 хувийг, улсын төсвийн (2022) 10.07 хувийг боловсролын салбарт зарцуулсан.

Сингапурын боловсролын систем төвлөрлөсөн тогтолцоотой. Боловсролын яамнаас олон төрлийн бодлого, хөтөлбөрийг яамны дүрэм, журмаар зохицуулдаг. Төр хувийн хэвшлийн түншлэл, сургалтын хөтөлбөрийг дэмждэг бөгөөд жишээ нь 2019 оноос хойш Боловсролын яам (MOE) нь SportSG болон Үндэсний урлагийн зөвлөл (NAC)-тэй хамтран “Стратегийн түншлэлийн хичээлээс гадуурх хөгжлийн үйл ажиллагаа” (SP-CCA) гэх төвлөрсөн, сургуулиас гадуурх сургалтын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хөтөлбөрт ерөнхий боловсролын дунд сургуулийн сурагчид спорт болон урлагийн сонирхлоо даган оролцох боломжтой.

Төрөөс дэмждэг гол хөтөлбөрүүд:

Хичээлээс гадуурх хөгжлийн үйл ажиллагаа (Co-Curricular Activities- CCA)

Боловсролын яамнаас хариуцан удирддаг. Дунд сургуулийн сурагчид заавал суралцах ёстой байдаг бөгөөд сургуулиудад хэрэгждэг. Дараах дөрвөн үндсэн ангилалд хуваагдана:

- Клуб, нийгэмлэгүүд
- Биеийн тамир, спорт
- Дүрэмт хувцастай бүлгүүд (скаут гэх мэт)
- Урлаг, уран сайхны үйл ажиллагаа (Дүрслэх урлаг, тайзны урлаг)

Эдгээр нь сурагчдын зан чанар, манлайлал, нийгмийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгддэг.

Edusave Scheme хөтөлбөр

Энэ нь Засгийн газрын санаачилга бөгөөд жил бүр сургуулиудад тэтгэлэг болон сурагчдад санхүүжилт олгож, нэмэлт сургалт, хөтөлбөрт хамрагдах боломжийг бүрдүүлдэг. Эдгээрийг Edusave Endowment Fund сан санхүүжүүлдэг бөгөөд сурагчдыг хичээлээс гадуурх чанартай хөтөлбөр, үйл ажиллагаанд хамрагдах нөхцөлийг бүрдүүлдэг.

Боловсролын санхүүжилт ба хуримтлалын хөтөлбөрийн тухай хууль- 1992 (The Education Endowment and Savings Schemes Act 1992) нь 1993 онд батлагдсан бөгөөд 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Edusave Endowment Fund сан 1993 онд Засгийн газрын нэгдсэн орлогын сангаас хөрөнгө шилжүүлснээр байгуулагдсан. Уг

сангийн хөрөнгийн үндсэн дүн 5.5 тэрбум сингапур доллар бөгөөд жил бүрийн хүүгийн орлогоор хөтөлбөрийн хүрээнд олгогдох зардлыг санхүүжүүлдэг. 2023 оны санхүүгийн жилд тус сангийн хүүгийн өгөөж нь жилийн 3.5 хувь байсан. 2023 оны санхүүгийн жилд сан нийт 250.7 сая долларын орлого олж, үүнээс 179.4 сая долларыг зарцуулсан байна. 2024 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар сангийн хөрөнгийн нийт үлдэгдэл 6.8 тэрбум долларт хүрсэн бөгөөд үүнд 1.3 тэрбум долларын хуримтлагдсан ашиг багтсан байна.

Энэ хөтөлбөрийн хүрээнд Сингапурын иргэн сурагчдын хувьд Эдусэйв (Edusave) данс автоматаар нээгддэг. Боловсролын яамны санхүүжилттэй ерөнхий боловсролын сургуульд суралцдаг нийт сурагчид, Боловсролын яамны санхүүжилтгүй сургуульд суралцдаг 7–16 насны сурагчид жил бүр тэтгэмж авна. Нэг хүүхдэд олгогдох тэтгэмж:

- Бага ангийн сурагч: 230 Сингапур доллар
- Дунд ангийн сурагч: 290 Сингапур доллар

Түүнчлэн 2025 оны 7-р сард нэг удаагийн 500 Сингапур долларын нэмэлт тэтгэмжлийг 2025 онд 13–16 настай 2009 оны 1-р сарын 1-нээс 2012 оны 12-р сарын 31-ний хооронд төрсөн) Сингапурын иргэн сурагчдын Edusave дансанд хийхээр төлөвлөж байна.

Боловсролын яамны санхүүжилттэй ерөнхий боловсролын сургуулийн сурагчид сургууль дээрх нэмэлт буюу хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрүүд болон бусад хөтөлбөр, сургалтын төхөөрөмж, тусгай хэрэгцээтэй сурагчдад зориулсан сургалтын төхөөрөмж зэрэгт ашиглах боломжтой бол Боловсролын яамны санхүүжилтгүй ерөнхий боловсролын сургуулийн сурагчид зөвхөн Сингапур улсад хэрэгждэг болон харьяалагдах сургуулийн нэмэлт буюу хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрүүдэд тэр дундаа хичээлийн үндсэн хөтөлбөртэй холбоотой хэл ярианы чадвар, жүжиг, бүтээлч бичлэг, авиа зүй (phonics), урлаг, шинжлэх ухаан, хөгжмийн сургалтууд, нийгэм-сэтгэлзүйн боловсролыг дэмжсэн адал явдалт болон манлайллын зуслангууд, боловсролын семинар, бага хурал, урам зориг өгөх сургалт, уулзалт, Сингапур дахь танин мэдэхүйн аялал жишээлбэл шинжлэх ухааны төв, амьтны хүрээлэн, музей, соёлын өв, үзэсгэлэн үзэх аяллууд, боловсролын сэтгүүл, цуврал хэвлэл худалдаж авах, математикийн олимпиад зэрэг тэмцээн уралдаанд оролцох бүртгэлийн төлбөрт ашиглах боломжтой.

Норвеги ХХИ- 2 (2023)

Баялгийн сангаас шууд бус байдлаар боловсролд чиглэсэн дэмжлэг үзүүлдэг, эрх зүй, санхүүгийн сайн тогтолцоотой улс. Тэгш хамруулалт сайтай, сургалтын хөтөлбөрүүд нь бүтээлч байдал, шүүмжлэлт сэтгэлгээ, ШИМТ хичээлүүд болон гадаад хэл зэрэгт түлхүү анхаардаг. Сурагчдад нэмэлт дэмжлэг, хувийн сургалтын төлөвлөгөө боловсруулах зэрэгт дэмждэгээс гадна хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан үнэ төлбөргүй сургалтын үйлчилгээг хэрэгжүүлдэг.

Иргэний нийгэм болон нутгийн удирдах байгууллагууд боловсролын салбарт хамтран ажиллах боломжийг хуулиар бүрдүүлсэн.

Боловсролын хөрөнгө оруулалт нь дэлхийд өндөрт тооцогддог (ДНБ-ний ~6.6%). 2022 онд ДНБ-ийхээ 3.97 хувийг, улсын төсвийн 10.12 хувийг боловсролын салбарт зарцуулсан.

Government Pension Fund Global (GPFГ) – гадаадад хөрөнгө оруулалт түлхүү хийдэг ч газрын тосны орлогоор улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлдэг. GPFГ болон төсвийн бодлогын дүрэм нь 2001 оноос хойш газрын тосны орлого, хөрөнгө оруулалтын өгөөжийг Норвегийн эдийн засагт үе шаттайгаар нэвтрүүлэх төлөвлөгөөг тодорхойлж өгсөн. Жилийн хөрөнгө оруулалтын бодит өгөөжийн хувийн тооцоололтой нийцүүлэхээр GPFГ болон төсвийн бодлогын дүрэмд заасан. 2001 онд анх төсвийн бодлогын дүрмийг тогтоох үед хөрөнгө оруулалтын бодит өгөөжийн хувь 4% гэж тооцсон бол 2017 оны хавар энэхүү тооцооллыг 3% болгож бууруулсан. Гэвч жилд улсын төсвийн 20 орчим хувийг GPFГ-ээс бүрдүүлж байна.

Казахстан ХХИ- 60 (2023)

Боловсролын тухай хууль, Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны тухай хууль нь боловсролын салбарт төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Багшийн нэр хүндийг дээшлүүлэх, цалин хөлсийг нэмэх, нэмэлт боловсролыг хөгжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, сурагчдын аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг төрөөс авсан нь боловсролын чанарыг сайжруулсан.

Санаачилга: “Тав тухтай сургууль” хөтөлбөрийг эхлүүлж, улсын хэмжээнд сургуулийн дэд бүтцийг шинэчлэхэд Самрук-Казына үндэсний баялгийн сангийн 100% эзэмшлийн Самрук-КазынаКонстракшн төслийг удирдах үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Мөн бүсийн засаг дарга нар энэхүү хөтөлбөрийн удирдах багт томоохон үүрэгтэй хамтран оролцдог.

Хөтөлбөрийн хүрээнд тэгш хамруулах бодлогыг хэрэгжүүлэхээс гадна спортын танхим, роботикийн лаборатори, дэвшилтэт технологийн төвүүд, бага болон дунд ангийн сурагчдад тусдаа байрлалтай хэсгүүдтэй байх ба тус бүр өөрийн хоолны газар болон спорт заалтай байхаар төлөвлөсөн. Өөр өөр төрлийн цаг уурын болон газар хөдлөлийн бүсүүдэд тохируулан боловсруулсан 300, 600, 900, 1,200, 1,500, 2,000, 2,500 сурагчдын багтаамжтай сургуулиуд нь мөн сурагчид болон багш нарын хэрэгцээнд нийцсэн, орчин үеийн эргономикийн стандартыг хангасан тоног төхөөрөмж, тавилга бүхий жагсаалтыг баталсан.

2024 оны байдлаар хөтөлбөрийн хүрээнд 104 сургууль ашиглалтад орсон байна. Үүний 43% нь хөдөө орон нутагт байрлалтай.

2022 онд ДНБ-ийхээ 4.46 хувийг, 2021 онд улсын төсвийн 24.09 хувийг боловсролын салбарт зарцуулсан.

Тав тухтай сургууль төсөлд улсын төсвөөс 2.3 их наяд тэнгэ төсөвлөсөн. Барилгын ажлыг 3 механизмаар хэрэгжүүлж байна. Үүнд: “Самрук-Казына Констракшн” компанийн шугамаар сургуулиудыг зорилтот байдлаар барих, аймгийн Засаг даргын Тамгын газар нь хувийн хөрөнгө оруулагчаас бэлэн барилгууд (9 сургууль) худалдан авах, мөн төр-хувийн хэвшлийн түншлэлээр барих хэлбэрүүд багтана. Үүний зэрэгцээ төслийг хэрэгжүүлэхэд хувийн хөрөнгө оруулалт татах зорилгоор дөрөв дэх механизмыг гаргасан. Энэ нь нэг талаас хувийн хөрөнгө оруулагч, нөгөө талаас тэргүүлэгч боловсролын байгууллагууд бүхий консорциум байгуулах юм.

Самрук-Казына бол төрийн өмчит хөрөнгийг удирдах, эдийн засгийн хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх зорилго бүхий үндэсний баялгийн сан.

2007 оны Боловсролын тухай хууль (2021 онд шинэчлэгдсэн)

2015 оны Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар төр хувийн хэвшлийн түншлэлээр боловсролын байгууллагуудын барилгын ажил (шинэчлэх) болон ашиглалт (цэцэрлэг, сургууль, оюутны дотуур байр)-ын төслийг хэрэгжүүлэх боломжтой.

Эстони ХХИ- 36 (2023)

Дижитал шилжилт, бүтээлч заах арга зүйгээр онцлог бөгөөд өргөн хүрээний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Төрөөс орон нутгийн засаг захиргаанд нийт санхүүжилтын 80 гаруй хувийг олгодог бөгөөд сургуулиуд нь бусад боловсролын системүүдтэй харьцуулахад илүү бие даасан, уян хатан шийдвэр гаргах боломжтой байдаг.

Мөн цогц боловсролыг зорилго болгодог бөгөөд хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааг дэмждэг. Сурагчдын дижитал бичиг үсэг тайлагдалт, сайн сайхан байдал зэрэгт анхаардаг бөгөөд сурагчдын гүйцэтгэл, сэтгэл ханамж өндөр. Үүнд боловсролын технологийн компаниудтай хамтран ажилладаг бөгөөд боловсролын инновацийг дэмжиж байна. Жишээ нь сургуулийн менежментийн арга хэрэгсэл болох eKool вэб системийг нийт сургуулийн 95% ашиглаж байна.

Бас нэгэн амжилттай санаачилга бол 7-13 настай охидод зориулсан роботик, технологийн Unicorn Squad клуб бөгөөд улс даяар 130 орчим клуб идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Цаашид 2025 оноос эхлэн хиймэл оюун ухааныг боловсролд нэвтрүүлэхээр олон улсын түншлэлд суурилан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд AI Leap Foundation төр хувийн хэвшлийн хамтарсан сан байгуулж, энэхүү хөтөлбөрийг удирдах бөгөөд төр, хувийн хэвшлээс санхүүжих аж. 2021 онд ДНБ-ийхээ 5.26 хувийг, улсын төсвийн 14.25 хувийг боловсролын салбарт зарцуулсан байна.

Солонгос улс ХХИ- 7 (2023)

Сургуулийн дараах үйл ажиллагаа хэрэгждэг бөгөөд сурагчид хагвон гэх хувийн сургалтын төвүүдэд шалгалтад бэлдэх зэрэг хувийн хичээл нэмэлтээр авдаг.

Мөн 2023 онд Neulbom School (edu-care) санаачилгыг нэвтрүүлсэн бөгөөд бага ангийн хүүхдүүдэд хичээлийн бус цагаар хамрагдах боломжийг олгож байна. 1-р ангийн хүүхдүүдэд үнэ төлбөргүй бөгөөд 2023 онд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Боловсролын яам KB Financial Group-тэй харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Хөтөлбөр нь тоглох, турших замаар суралцах аргад суурилсан бөгөөд код бичих, урлаг, спорт зэрэг чиглэлээр явагдаж байгаа бөгөөд энэ нь мөн эцэг, эх, асран хамгаалагчдын асрахуйн ачааллыг хөнгөвчлөх зорилготой.

KB Financial Group 2023 оноос 2027 он хүртэлх таван жилийн хугацаанд нийт 500 тэрбум вон (ойролцоогоор 38.5 сая ам.доллар)-ны хандив өгөх амлалт өгсөн бөгөөд энэхүү хандив нь Боловсролын яамны бага ангийн хүүхдүүдэд зориулсан асрахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөг дэмжих зорилготой юм. Мөн хандивын зарим хэсгийг бүс нутгийн асрахуйн институт байгуулах, Нильбом (Neulbom) сургуулийн хөтөлбөрийн хүрээнд эдийн засаг, санхүүгийн үнэ төлбөргүй боловсролын сургалтуудыг санхүүжүүлэхэд зарцуулах аж.

Солонгос улс 2021 онд ДНБ-ийхээ 4.87 хувийг боловсролын салбарт зарцуулсан. Мөн улсын сургуулиудад орлого багатай өрхийн хүүхдүүдэд зориулсан нэмэлт сургалт, засгийн газрын санхүүжилттэй хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Исланд ХХИ- 1 (2023)

Исландын Рейкьявик хот 2007 онд 6–18 насны бүх хүүхдэд зориулсан “Чөлөөт цагийн карт” (Frístundakort) хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хэд хэдэн хотууд дагаж энэ санаачилгыг хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүд жил бүр санхүүгийн дэмжлэг авч, спорт, урлаг, хөгжмийн сургалт зэрэг чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцох боломжтой болдог. 2023 онд тус хотод хууль ёсны оршин суух эрхтэй хүүхдүүдэд нийгэм, эдийн засгийн байдлаас үл хамааран 75,000 исланд крон (579 ам.доллар) олгохоор тогтсон байна.

Энэхүү тэтгэмжийг хотын төсвөөс гаргадаг бөгөөд Соёл, спортын газраас удирдан зохион байгуулдаг. Хүүхдийн эцэг, эх, гэр бүлд шууд мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгогддоггүй. Харин эцэг эх, асран хамгаалагчид цахим системээр дамжуулан уг тэтгэмжийг зөвшөөрөгдсөн дугуйлан, клуб зэрэг байгууллагат хуваарилдаг. Эдгээр байгууллага нь үйл ажиллагааны төлбөрийг хотын захиргаанаас нэхэмжилж авдаг бөгөөд хэрэв тухайн сургалтын төлбөрийн зөрүү байгаа тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагчид нь төлнө. Цахим системд зөвшөөрөлтэй бүх дугуйлан, сургалтын байгууллагууд бүртгэлтэй бөгөөд эцэг, эх, асран хамгаалагчид системд нэвтрэн сонголт болон мөнгөн дүнгээ хуваарилах, сургалтын байгууллага нөхөн төлбөрийн нэхэмжлэх боломжтой.

---oOo---

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТУХАЙ ТАЙЛАН

НЭГ.НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Хүүхдийн хөгжлийн тухай хуулийн төсөлд шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийн, түүний үр нөлөөг тооцож, хуулийн төслийг боловсронгуй болгоход энэхүү үнэлгээний ажлын зорилго оршино.

Хүүхдийн хөгжлийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

- 1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 2.Хуулийн төслийн үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах, хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх;

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Практикт хэрэгжих боломж
4. Зардал
5. Харилцан уялдаа

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 7-д “Сурч боловсрох эрхтэй” болон 11-д “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасныг хангахад шууд чиглэгдэж байна. Түүнчлэн Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэх, хүүхэд бүр хөгжлийн үйл явцад тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх, хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагааг төрөөс дэмжих, санхүүжүүлэх, зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилтод хүрэх боломжтой эсэхийг үнэллээ.

“Практикт хэрэгжих боломж” хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл учраас шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага гэдгийг тодорхойлоход Дорнод аймагт “Хүн болох багаасаа” хүүхэд хөгжлийн хөтөлбөрийг практикт хэрэгжүүлсэн туршлагыг жишиг болгон ашигласан. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалтад Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх, үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөж байгаа зохицуулалтыг сонгож авсан.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарах этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн хэрэгжилтийн зардлыг тухайн төсвийн жилд тодорхойлох байдлаар зохицуулалт хийх бөгөөд тайланг Зардлын тооцооны тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт нь холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Хүүхэд хөгжлийн хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын иргэний “Сурч боловсрох эрх болон, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалах үйл ажиллагааны үндсэн арга механизм нь хүүхэд бүр хөгжлийн үйл явцад тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх, хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагааг төрөөс дэмжих, санхүүжүүлэх, зохион байгуулах бодлогыг хэрэгжүүлэхэд оршино. Энэ зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Тухайлбал:

- ✓ Хүүхдийн оролцоонд суурилсан хөгжлийг дэмжих, нас насанд нь тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хөгжлийн ялгаатай байдал, олон янз байдлыг харгалзан үзэж тэгш хамруулах;

- ✓ Хүүхэд хөгжлийн чиглэлээр хот ба хөдөөгийн ялгааг арилгах, багш, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудал шийдэл хүлээж байгаа бөгөөд эдгээрийг салбарын бодлогоор бус салбар дундын, улс орон даяар хэрэгжих хууль зүйн цогц зохицуулалтаар шийдвэрлэх;
- ✓ Хүүхдийн хөгжлийн дэмжихэд төрөөс баримтлах бодлого хэрэгжилтийн механизм, санхүүжилтийн тогтолцоог сайжруулах;
- ✓ Хүүхдийн хөгжлийг дэмжих тогтолцоог төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны түншлэл дээр тулгуурлан хэрэгжүүлэх;

Иймд Хүүхдийн хөгжлийн тухай хуулийн төслөөс дээрх зорилтуудтай холбогдсон, эдгээр зорилтуудыг хангах зорилгоор тусгагдсан зүйл заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг тооцно. Үүнд:

3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. (Хуулийн төсөл нь 19 зүйлтэй.)

№	Зорилгод хүрэх байдал/ дагалдах зорилтууд	Сонгосон зүйл заалт
1.	Хүүхдийн оролцоонд суурилсан хөгжлийг дэмжих, нас насанд нь тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хөгжлийн ялгаатай байдал, олон янз байдлыг харгалзан үзэж тэгш хамруулах;	Хуулийн төслийн 4.2, 5.1, 5.2, 6.1.2 дугаар зүйл
2.	Хүүхэд хөгжлийн чиглэлээр хот ба хөдөөгийн ялгааг арилгах, багш, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудал шийдэл хүлээж байгаа бөгөөд эдгээрийг салбарын бодлогоор бус салбар дундын, улс орон даяар хэрэгжих хууль зүйн цогц зохицуулалтаар шийдвэрлэх;	Хуулийн төслийн 5.3, 6.1.1, 7.1.2, 9.1.4, 12.6 дүгээр зүйл
3.	Хүүхдийн хөгжлийн дэмжихэд төрөөс баримтлах бодлого хэрэгжилтийн механизм, санхүүжилтийн тогтолцоог сайжруулах;	Хуулийн төслийн 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.1.7, 7.1.3, 16 дугаар зүйл
4.	Хүүхдийн хөгжлийг дэмжих тогтолцоог төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны түншлэл дээр тулгуурлан хэрэгжүүлэх;	Хуулийн төслийн 6.1.7, 10.1, 10.2, 10.3, 14 дүгээр зүйл

3.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэхийг шалгав.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл заалт
7.1.1.Хүүхдийн хөгжлийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөгжлийн төв, дэд бүтцийн төсвийг батлах; 7.1.2.Улсын төсөв, Үндэсний баялгийн сангаас жил бүр олгох хүүхдийн хөгжилд зарцуулах хувь хэмжээг тогтоохно; 7.1.3.Тухайн жилд зарцуулагдах нэг хүүхдэд ногдох хүүхдийн хөгжлийн нэрийн дансанд байрших санхүүжилтийн дэмжлэгийг бүс нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хүүхдийн тоо зэргийг харгалзан батална.	Хуулийн төслийн 7 дугаар зүйл
8.1.1.Улсын хэмжээнд хүүхдийн хөгжлийнх үйл ажиллагааны бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах; 8.1.2.Хичээлээс гадуур хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, өргөн мэдүүлэх;	Хуулийн төслийн 8 дугаар зүйл
11.1.Энэ хуулийн 12.4-т заасан хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааг дэмжих бүтээн байгуулалт, дэд бүтэц, тоног төхөөрөмжтэй холбоотой төсвийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэнэ.	Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг
12.2.Хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах; 12.3.Энэ хуулийн 9.1.3-т заасан мэдээллийн санд харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа хувь, хүн хуулийн этгээдийн бүртгэлийг оруулах ажлыг зохион байгуулах; 12.4.Харьяалах нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, түүнд шаардлагатай барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг бүтээн байгуулахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгах, 12.5.Энэ хуулийн 10.1-т заасан хөгжлийн төвийг харьяалах нутаг дэвсгэртээ байгуулахдаа тухайн орон нутгийн сургууль, цэцэрлэг, соёлын төв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн барилга байгууламжийг тэргүүн ээлжид ашиглах тухай шийдвэрийг гаргах, 12.6.Харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа энэ хуулийн 10.1-т заасан хүүхдийн хөгжлийн төвийн	Хуулийн төслийн 12-р зүйлийн 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6 дахь хэсэг

жишиг дүрмийг баталж мөрдүүлэх, түүнд хөгжлийн үйл ажиллагаа явуулах хувь хүн, хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн сонгон шалгаруулан гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, холбогдох санхүүжилтийг шийдвэрлэнэх	
13.1.Хүүхдийн оролцоонд суурилсан хичээлээс гадуурх үйл ажиллагаа, клуб, секц, дугуйланг тогтмол зохион байгуулна.	Хуулийн төслийн 13.1 дэх хэсэг

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. (Хуулийн төсөл 7 зүйлтэй)

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 4.2, , 5.1, 5.2, 5.3, 6.1.1, 6.1.2, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.1.7 7.1.2, 7.1.3 9.1.4, 10.1, 10.2, 10.3, 12.6, 14, 16 дугаар зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж		Практикт туршилт хийх, практикт тухайн төрлийн харилцаа, чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдээс ярилцлага авах, гарч болох хүндрэлийг судлах
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийг төслийг шалгах
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 7, 8, 10, 11, 12 дугаар зүйл, 13.1 дугаар зүйлийн 13.1 дахь хэсэг	Хуулийн төслөөс иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэж буй эсэхийг шалгах
5.	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх
6.	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.

Энэ хэсэгт дээрх сонгож авсан зохицуулалтууд нь хуулийн төслийн боловсруулагдах үндэслэл, хэрэгцээ шаардлагад тусгагдсан асуудлыг шийдвэрлэж чадах эсэхийг үнэлэх байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Нэг.Хүүхдийн оролцоонд суурилсан хөгжлийг дэмжих, насанд нь тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хөгжлийн ялгаатай байдал, олон янз байдлыг харгалзан үзэж тэгш хамруулах зорилгын хүрээнд

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлнэ”, “Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулна”, “Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ” гэж тодорхой тусгасан.

Тус зорилгын хүрээнд хуулийн төслийн дараах заалтууд нийцэж байна. Үүнд:

2.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч буй 6-16 насны хүүхдийг хамарсан хичээлээс гадуурх үйл ажиллагаа, түүнд төр, орон нутгийн байгууллага, боловсролын болон соёл, спортын байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд, хуулийн этгээд, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог зохицуулна.

4.2.Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь нас, сонирхол, хөгжлийн онцлогт нийцсэн байна.

5.1.Хүүхэд өөрийн сонирхолд нийцсэн үйл ажиллагаанд сайн дурын үндсэн дээр оролцоно.

5.2.Хүүхдийн санал, санаачилгыг үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгана.

5.3.Хүүхэд өөрийн харьяалагдах Ерөнхий боловсролын сургууль болон өөрийн оршин суугаа газартаа хамгийн ойр харьяалах Хүүхэд хөгжлийн төвийн энэ хуулийн 4.1-т заасан чиглэлийн сургалтад жилд 6 сараас доошгүй хүртэл сарын хугацаанд хамрагдаж болно.

6 дугаар зүйл.Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг, оролцоо

6.1.Хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч дараах байдлаар оролцоно. Үүнд:

6.1.1.эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийн оюун ухаан, сэтгэл зүй, бие бялдар, авьяас, ур чадвар, сонирхлын хөгжлийг дэмжих, хичээлээс гадуур өөрийгөө хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдах боломжийг хангах нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх;

6.1.2.хүүхдийн үзэл бодол, сонирхол, хэрэгцээг сонсож, шийдвэр гаргах үйл явцад оролцуулан, нас, онцлог, хөгжил, сонирхол, хэрэгцээнд нийцсэн байдлаар шийдвэр гаргах;

6.1.3.зөвшөөрөгдсөн хөгжлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийн талаарх мэдээллийг тогтмол авч, үнэлэлт дүгнэлт өгөх;

Дээрх зохицуулалтууд нь хүүхэд өөрийн хүсэл сонирхол, насны онцлогтой тохирсон хүүхдийн хөгжлийн хөтөлбөрүүдэд хамрагдах боломжуудыг хуулиар тодорхой зохицуулсан байна.

Хоёр.Хүүхэд хөгжлийн чиглэлээр хот ба хөдөөгийн ялгааг арилгах, багш, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудал шийдэл хүлээж байгаа бөгөөд эдгээрийг салбарын бодлогоор бус салбар дундын, улс орон даяар хэрэгжих хууль зүйн цогц зохицуулалтаар шийдвэрлэх зорилгын хүрээнд

Монгол Улсад алслагдсан дүүрэг болон орон нутгийн түвшинд хүүхдэд зориулсан ногоон байгууламж, спортын талбай, чөлөөт цагаа өнгөрөөх төвүүд хомс. Сургуулийн хичээлийн бус цагаар хүүхдүүд хяналтгүй, хөндлөнгийн оролцоогүй нөхцөлд гадуур сэлгүүцэх, цахим орчинд хорт агуулгад автах эрсдэл нэмэгддэг. Ялангуяа хүүхдийн хөгжлийн төвүүд хүрэлцээгүй, дугуйлангийн хамрагдалт бага байгаа нь хүүхдийн оролцоог сулруулж, зан үйлийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хүүхдийн хөгжлийн чиглэлээр ажиллах мэргэжлийн боловсон хүчин хомс, ялангуяа орон нутагт сургууль, цэцэрлэгийн багш нарын ажлын ачаалал өндөр, нэмэлт хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулах боломжгүй, сургалтын хөтөлбөр, арга зүй шинэчлэгдээгүй, орчин үеийн хүүхдүүдийн хэрэгцээг шаардлага сонирхлыг хангахгүй байна. Мөн санхүүжилтийн хөшүүрэг байхгүйгээс хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр боловсон хүчин бэлтгэгдэх, чадавхжуулах боломж бүрдэхгүй байна.

Иймд тус хуулийн төслийн хүрээнд дараах зохицуулалтууд хүүхдийн хөгжлийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын санхүүгийн мэргэжлийн боловсон хүчний дэмжлэгийг бодлогоор дэмжих зохицуулалтууд тусгагдсан байна. Хуулийн төслийн

7.1.2.Улсын төсөв, Үндэсний баялгийн сангаас жил бүр олгох хүүхдийн хөгжилд зарцуулах хувь хэмжээг тогтоох;

7.1.3.тухайн жилд зарцуулагдах нэг хүүхдэд ногдох хүүхдийн хөгжлийн нэрийн дансанд байрших санхүүжилтийн дэмжлэгийг бүс нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хүүхдийн тоо зэргийг харгалзан батална.

8 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

8.1.Засгийн газар нь хүүхдийн хөгжлийг дэмжихэд дараах бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

8.1.1.улсын хэмжээнд хүүхдийн хөгжлийнх үйл ажиллагааны бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

8.1.2.хичээлээс гадуур хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, өргөн мэдүүлэх;

8.1.3.хүүхдийн хөгжлийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.

9 дүгээр зүйл.Хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

9.1. Хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй:

9.1.1.хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тайлагнах;

9.1.2.хүүхдийн асуудал хариуцсан бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

9.1.3.хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагч, хувь хүн, хуулийн этгээдийн бүртгэлийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх;

9.1.4.аймаг, сум, дүүрэг дэх энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т заасан хүүхдийн хөгжлийн төвд үйл ажиллагаа явуулах, энэхүү хуульд заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх хувь хүн, хуулийн этгээдийн сонгон шалгаруулах, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана.

10 дугаар зүйл. Хүүхдийн хөгжлийн төвийн чиг үүрэг

10.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь тухайн орон нутгийн хүүхдийн тоо, нутаг дэвсгэрийн байршил, барилга байгууламжийн хүрэлцээ дээр тулгуурлан энэ хуулийн 4.1-т заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулах сургалт, дугуйлан зохион байгуулах хүүхдийн хөгжлийн төвийг төвлөрсөн болон төвлөрсөн бусаар байгуулна.

10.2.Хүүхэд хөгжлийн төвийг байгуулахдаа тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, соёлын төв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн барилга байгууламжийг тэргүүн ээлжид ашиглах арга хэмжээг авна.

10.3.Хүүхдийн хөгжлийн төвд сонгон шалгаруулалтаар шалгарсан энэ хуулийн 4.1-т заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулах хувь хүн, хуулийн этгээд гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

11 дүгээр зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын чиг үүрэг

11.1.Энэ хуулийн 12.4-т заасан хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааг дэмжих бүтээн байгуулалт, дэд бүтэц, тоног төхөөрөмжтэй холбоотой төсвийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын чиг үүрэг

12.1.Хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

12.2.Хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

12.3.Энэ хуулийн 9.1.3-т заасан мэдээллийн санд харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа хувь, хүн хуулийн этгээдийн бүртгэлийг оруулах ажлыг зохион байгуулах;

12.4.Харьяалах нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, түүнд шаардлагатай барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг бүтээн байгуулахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгах;

12.5.Энэ хуулийн 10.1-т заасан хөгжлийн төвийг харьяалах нутаг дэвсгэртээ байгуулахдаа тухайн орон нутгийн сургууль, цэцэрлэг, соёлын төв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн барилга байгууламжийг тэргүүн ээлжид ашиглах тухай шийдвэрийг гаргах;

12.6.Харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа энэ хуулийн 10.1-т заасан хүүхдийн хөгжлийн төвийн жишиг дүрмийг баталж мөрдүүлэх, түүнд хөгжлийн үйл ажиллагаа явуулах хувь хүн, хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн сонгон шалгаруулан гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, холбогдох санхүүжилтийг шийдвэрлэнэ.

Дээрх зохицуулалтууд нь хүүхдийн оролцоонд суурилсан хөгжлийг дэмжих, нас насанд нь тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хөгжлийн ялгаатай байдал, олон янз байдлыг харгалзан үзэж тэгш хамруулах, үүнтэй уялдаатайгаар хот ба хөдөөгийн ялгааг арилгах, багш, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудлыг шийдэх зохицуулалтын шат шатны төрийн байгууллага болон тухайн орон нутгийн боловсролын байгууллагад тодорхой чиг үүргүүдийг ногдуулж, түүнийг санхүүжүүлэх төсвийг тодорхой шийдсэн зохицуулалтууд тусгагдсан байна.

Гурав.Хүүхдийн хөгжлийн дэмжихэд төрөөс баримтлах бодлого хэрэгжилтийн механизм, санхүүжилтийн тогтолцоог сайжруулах зорилгын хүрээнд

Хүүхдийн хөгжлийг дэмжих тэр дундаа хүүхдийн сонирхолд чиглэсэн хичээлээс гадуурх хөгжлийн үйл ажиллагаагаар ирээдүйн бие хүн болж төлөвшихөд төрөөс үзүүлэх бодлогын дэмжлэгийг бие даасан хууль, санхүүжилт, хэрэгжилтийн механизмаар зохицуулалт байхгүй байсан бөгөөд хуулийн төслийн дараах заалтуудаар санхүүжилтийн механизмыг тодорхой болгосон байна.

8.1.1.Улсын хэмжээнд хүүхдийн хөгжлийнх үйл ажиллагааны бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

8.1.2.Хичээлээс гадуур хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, өргөн мэдүүлэх;

10.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь тухайн орон нутгийн хүүхдийн тоо, нутаг дэвсгэрийн байршил, барилга байгууламжийн хүрэлцээ дээр тулгуурлан энэ хуулийн 4.1-т заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулах сургалт, дугуйлан зохион байгуулах хүүхдийн хөгжлийн төвийг төвлөрсөн болон төвлөрсөн бусаар байгуулна.

10.2.Хүүхэд хөгжлийн төвийг байгуулахдаа тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, соёлын төв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн барилга байгууламжийг тэргүүн ээлжид ашиглах арга хэмжээг авна.

10.3.Хүүхдийн хөгжлийн төвд сонгон шалгаруулалтаар шалгарсан энэ хуулийн 4.1-т заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулах хувь хүн, хуулийн этгээд гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

15 дүгээр зүйл.Санхүүгийн эх үүсвэр

15.1.Хүүхдийн хөгжлийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

15.1.1.Үндэсний баялгийн сангаас жил бүр батлагдсан хөрөнгө;

15.1.2.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;

15.1.3.Олон улсын байгууллага, хувийн хэвшлийн хандивлагчийн санхүүжилт зэрэг болно.

15.2.Хүүхдийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

16 дугаар зүйл.Хүүхдийн хөгжлийг санхүүжүүлэх журам

16.1.Хүүхдийн хөгжлийн төвийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн санхүүжилт нь орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

16.2.Хүүхдийн хөгжлийн төв дээр үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн сургалтын төлбөрийн хэмжээг тухайн жилийн санхүүжилт, зах

зээлийн үзүүлэлт зэрэг дээр тулгуурлан нэг хүүхдэд оногдох дэмжлэгийн хэмжээг энэ хуулийн 9.1-т заасан төрийн захиргааны төв байгууллага батална.

16.3.Хүүхдийн хөгжлийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагчийн санхүүжилтийг тухайн шатны засаг дарга талуудын хооронд байгуулагдсан гэрээнд заасны дагуу сар бүрийн 25-ны өдрийн дотор тухайн орон нутгийн хүүхдийн хөгжил хариуцсан төрийн захиргааны байгууллагын санхүүжилтийн мэдэгдлийг үндэслэн олгоно.

Монгол улс нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хуваарилах, хуримтлуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 4 сарын 19-нд баталсан. Тус хуулийн хүрээнд Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжсөн сантай байх бөгөөд үйл ажиллагааны зарчим нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тулгуурласан байхаар тусгасан.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд Улсын Их хуралд “Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан Хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг хэлэлцэн батлах” эрхийг олгосон тул тус зохицуулалтын хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих сургалт, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх механизмийг тодорхойлсон хууль тогтоомжийг баталж, түүнийг санхүүжүүлэх арга замыг Баялгийн сангаас шийдвэрлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.

Дөрөв.Хүүхдийн хөгжлийг дэмжих тогтолцоог төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны түншлэл дээр тулгуурлан хэрэгжүүлэх,

Хуулийн төслийн дараах заалтуудаар

10.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь тухайн орон нутгийн хүүхдийн тоо, нутаг дэвсгэрийн байршил, барилга байгууламжийн хүрэлцээ дээр тулгуурлан энэ хуулийн 4.1-т заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулах сургалт, дугуйлан зохион байгуулах хүүхдийн хөгжлийн төвийг төвлөрсөн болон төвлөрсөн бусаар байгуулна.

10.2.Хүүхэд хөгжлийн төвийг байгуулахдаа тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, соёлын төв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн барилга байгууламжийг тэргүүн ээлжид ашиглах арга хэмжээг авна.

10.3.Хүүхдийн хөгжлийн төвд сонгон шалгаруулалтаар шалгарсан энэ хуулийн 4.1-т заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулах хувь хүн, хуулийн этгээд гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

14.1. Хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагч нь энэ хуулийн 4.1-т заасан хичээлээс гадуурх үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна гэсэн зохицуулалтуудаар хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааг гардан зохион байгуулах үйл явц мэргэжлийн хувийн хэвшлийн үйл ажиллагаа дээр тулгуурлан явж байгаа учраас хүртээмжтэй хувийн хэвшлийн үйл ажиллагаа дэмжсэн зохицуулалт болсон тул урт хугацаанд тогтвортой чанартай үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэх боломжтой гэж үзлээ.

4.2. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.

Энэхүү хуулийн хүрээнд хүүхэд бүр хөгжлийн үйл явцад тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх, хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагааг төрөөс дэмжих, санхүүжүүлэх, зохион байгуулахтай холбогдсон харилцаанд төрийн байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн үндсэн чиг үүргийг илүү тодорхой болгож өгсөн, мөн хүүхэд болон эцэг эх, хувийн хэвшлийн хууль эрх зүйн хүрээнд болон практикт хэвшсэн эрх, үүрэг, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжих боломжтой зохицуулалтуудыг нарийвчлан тодорхойлсон учир талуудад хүлээн зөвшөөрөгдөх байдлын хувьд холбогдох шаардлагыг хангасан байна.

4.3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ.

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөлд холбогдох байгууллагаас тусгайлан санал ирээгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан “Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага”, 30 дугаар зүйлд заасан “Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага хангасан эсэх” мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг судалж үнэллээ.

Дээрх байдлаар хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хуулийн төсөл нь нийтлэг байдлаараа хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байна.

4.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ. Үүнд:

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн тодорхой зорилтуудыг дэвшүүлэн тэдгээр зорилтуудад хүрэх

	шууд утга бүхий заалтуудыг оруулсан тул зорилтдоо хүрсэн гэж үзсэн.
Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн 3 дугаар зүйлд заасан тодорхойлсон нэр томъёо нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан зүйл тогтоогдоогүй.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан зүйл тогтоогдоогүй
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төсөлд Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зүйл тогтоогдоогүй.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Төрийн байгууллагын чиг үүргийг шилжүүлсэн зүйл төсөлд тогтоогдоогүй.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон тухай ямар нэгэн зүйл заалт тусгаагүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төсөлд зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтын талаар тусгаагүй байна.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Хуулийн төсөлд аливаа хүний эрхийг хязгаарласан зохицуулалт байхгүй байна.
Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөлд жендерийн эрх тэгш байдал хөндөгдөөгүй.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх	Төсөлд ямарваа нэгэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар заалт ороогүй болно.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Дүгнэлт, зөвлөмж.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ. Энэхүү хуулийн төсөлд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу холбогдох судалгаа хийгдсэн тул энэхүү судалгааны дүгнэлт, хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулах шаардлагатай.

Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлалаас дөрвөн төрлийн зорилгыг тодорхойлж, эдгээр зорилгод хуулийн төслийн зүйл заалт хэрхэн нийцэж байгаад үнэлгээ хийсэн. Үнэлгээний дагуу хуулийн төслийн зорилго нь төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан гэж үзэж байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага хангасан эсэх, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг судалсан.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төсөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд дан ганц байгальд үзүүлэх нөлөөллөөс гадна нийгэмд үзүүлэх нөлөөлөл, түүний талаар оролцогч талуудын мэдэх эрх, оролцооны түвшинг бодитойгоор хангах, төслийн ангиллаас хамааруулан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний түвшин өөр өөр байхыг тусгаж өгсөн нь оролцогч талуудад хүртээмжтэй, тэгш, хүндрэл багатайгаар шийдвэрлэсэн хэлбэр хэмээн үзэж байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэлэхэд эерэг байна.

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нэг.Ерөнхий үндэслэл

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасан байна.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамрагдах хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг дээр дурдсанчлан “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 12.1.4-т заасан буюу Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэнэ/-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

“Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль”-ийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, зардлыг бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2 дугаар зүйлд “Тохиолдлын тоо нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Ингэхдээ статистикийн тоо мэдээг ашиглах бөгөөд энэ талаар статистик тоо мэдээ байхгүй бол баримжаалж тооцно.” гэж заасан болон 4.4.2 дугаар зүйлд “Зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авах бөгөөд тэдгээрийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээгээр баримжаалж тогтооно.” гэж тус тус заасныг үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, тухайн салбарын мэргэжилтний мэдээлэл, саналыг баримтлан баримжаалах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтооно.

Хоёр.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардал.

Энэ хэсэгт тухайн хуулийн төсөл батлагдсанаар хувь хүн, хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараахь үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- ✓ Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- ✓ Хуулийн этгээдийн зардлыг тооцох;
- ✓ Хуулийн этгээдийн зардлын тоон үзүүлэлтийг тооцох;
- ✓ Нийт зардлын дүнг тооцож гаргах;

- ✓ Хялбарчлах буюу зардлыг бууруулах боломжийг шалгах;
- ✓ Хуулийн этгээдийн нэмэлт зардлыг тооцох;

Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж, уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын 2.2-т “Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг тооцно” гэж заасан.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд үүрэг болгосон буюу шууд зардал үүсгэх болон шууд бусаар зардал үүсгэж болзошгүй гэж үзэж болох агуулга бүхий дараах зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

№	Хуулийн төслийн зүйл заалтын дугаар	Зохицуулалт
1.	Хуулийн төслийн 9.1.3 дахь заалт	9.1.3.хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн бүртгэлийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх.
2.	Хуулийн төслийн 9.1.4 дэх заалт	9.1.4.аймаг, сум, дүүрэг дэх энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т заасан хүүхдийн хөгжлийн төвд үйл ажиллагаа явуулах, энэхүү хуульд заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх хувь хүн, хуулийн этгээдийн сонгон шалгаруулах, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана.
3.	Хуулийн төслийн 10.2 дахь хэсэг	10.2.Хүүхэд хөгжлийн төвийг байгуулахдаа тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, соёлын төв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн барилга байгууламжийг тэргүүн ээлжид ашиглах арга хэмжээг авна.
4.	Хуулийн төслийн 12.5 дахь хэсэг	12.5.Энэ хуулийн 10.1-т заасан хөгжлийн төвийг харьяалах нутаг дэвсгэртээ байгуулахдаа тухайн орон нутгийн сургууль, цэцэрлэг, соёлын төв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн барилга байгууламжийг тэргүүн ээлжид ашиглах тухай шийдвэрийг гаргах.
5.	Хуулийн төслийн 13.1 дэх хэсэг	13.1. Хүүхдийн оролцоонд суурилсан хичээлээс гадуурх үйл ажиллагаа, клуб, секц, дугуйланг тогтмол зохион байгуулна.
6	Хуулийн төслийн 13.3 дахь хэсэг	13.3.Бүх шатны боловсролын байгууллага нь үндсэн сургалтын цагаас бусад цагт тухайн сургуулийг хүүхэд хөгжлийн төвөөр ажиллуулах боломжоор хангана.
7	Хуулийн төслийн 14.2 дахь хэсэг	14.2.Хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нартай хүүхдийг хөгжүүлэх, суралцуулах талаар хариуцлагын гэрээ

		байгуулж, эргэх холбоотой тогтмол харилцаж, санал хүсэлтийг хүлээн авч, тухай бүр шийдвэрлэн хамтран ажиллана.
8	Хуулийн төслийн 14.3 дахь хэсэг	14.3.Сургалт, дугуйланд хамрагдаж буй хүүхдүүдийг уралдаан, тэмцээн, хөгжлийн олон талт үйл ажиллагаанд оролцуулж, хүүхдүүдийн бүтээл, авьяас ур чадвар, амжилтыг эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтэд танилцуулж байна.
9	Хуулийн төслийн 14.4 дэх хэсэг	14.4.Хөгжлийн үйл ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнг сайжруулах чиглэлээр санал санаачилга гаргаж, засаг дарга болон төрийн холбогдох байгууллагууд, багш нар, эцэг эх, асран хамгаалагч нартай нээлттэй хамтран ажиллана.

Хэдийгээр хуулийн төсөлд хуулийн этгээдэд (сургалтын байгууллагууд болон хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулагчдад) хүлээлгэсэн дээрх зохицуулалтууд тусгагдсан боловч эдгээр нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох эрх зүйн актын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байна.

Өөрөөр хэлбэл дээрх зохицуулалтууд нь зардал шинээр үүсгэх зохицуулалт биш хууль болон эрх бүхий субъектын тогтоол, шийдвэрээр баталсан эрх зүйн актын дагуу хэрэгжиж байгаа, практикт хэвшсэн зохицуулалт байна. Хуулийн төслийн аливаа зардлыг зөвхөн шинээр зохицуулсан, нэмэлт үүрэг хүлээлгэсэн, уг үүргээс хамааран нэмэлт болон шууд зардал гарах тохиолдолд, өргөжүүлсэн хүрээнд тооцох болно.

Төсөлд тусгагдсан хуулийн этгээдэд үүрэг болгосон заалтууд нь хэдийгээр одоогоор хуульд тусгагдаагүй хэдий ч хуулийн этгээдийн хүлээх үүргийн хүрээнд агуулгаараа багтсан байх тул хуулийн этгээдэд нэмэлт зардал гаргах зохицуулалт биш болно. Өөрөөр хэлбэл тухайн сургалтын байгууллага болон хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулагч өөрийн чиглэл, үйл ажиллагаа, цар хүрээндээ ажиллах бөгөөд энэ нь хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсгэхгүй.

Гурав.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардал.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо дараах дарааллыг баримтална. Үүнд:

- ✓ Иргэний гүйцэтгэх үүргийг тодорхойлох;
- ✓ Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- ✓ Тоон үзүүлэлтийг тооцох;
- ✓ Нийт дүнг тоцож гаргах;
- ✓ Хялбарчлах буюу зардлыг бууруулах боломжийг шалгах.

Энэ үе шатанд Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгагдсан иргэний гүйцэтгэх үүргийг болон түүний мэдээллийн агуулгыг нэг бүрчлэн тодорхойлж, иргэнд үүсэх зардлын цаг хугацааны ачааллаар тооцдог болохыг дурдъя.

Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн этгээд болон төрийн байгууллагад үүрэг болгосон зарчмуудыг тусгасан байх бөгөөд иргэнд үүрэг болгосон заалтууд нь шууд зардал үүсгэхээр заалтууд байхгүй байна. Харин хуулийн төсөлд иргэний эрхийг хангах, иргэнд эрх олгосон дараах зохицуулалтууд байна. Үүнд:

№	Хуулийн төслийн зүйл заалтын дугаар	Зохицуулалтууд
1.	Хуулийн төслийн 5.1 дэх хэсэг	5.1.Хүүхэд өөрийн сонирхолд нийцсэн үйл ажиллагаанд сайн дурын үндсэн дээр оролцоно.
2.	Хуулийн төслийн 5.3 дахь хэсэг	5.3.Өөрийн оршин суугаа газартаа хамгийн ойр харьяалах Хүүхэд хөгжлийн төвийн энэ хуулийн 4.1-т заасан чиглэлийн сургалтад жилд 6 хүртэл сарын хугацаанд хамрагдаж болно.
3.	Хуулийн төслийн 6.1.1 дэх заалт	6.1.1.эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийн оюун ухаан, сэтгэл зүй, бие бялдар, авьяас, ур чадвар, сонирхлын хөгжлийг дэмжих, хичээлээс гадуур өөрийгөө хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдах боломжийг хангах нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх.
4.	Хуулийн төслийн 6.1.2 дахь заалт	6.1.2.хүүхдийн үзэл бодол, сонирхол, хэрэгцээг сонсож, шийдвэр гаргах үйл явцад оролцуулан, нас, онцлог, хөгжил, сонирхол, хэрэгцээнд нийцсэн байдлаар шийдвэр гаргах.
5.	Хуулийн төслийн 6.1.3 дахь заалт	6.1.3.зөвшөөрөгдсөн хөгжлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийн талаарх мэдээллийг тогтмол авч, үнэлэлт дүгнэлт өгөх.
6.	Хуулийн төслийн 6.1.4 дэх заалт	6.1.4.багш, хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагчтай харилцаж, хамтран ажиллах.
7.	Хуулийн төслийн 6.1.5 дахь заалт	6.1.5.хөгжлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилт, хамрагдалтад хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд байгууллагад санал хүргүүлэх.
8.	Хуулийн төслийн 6.1.6 дахь заалт	6.1.6.хүүхдийн нэр дээрх хөгжлийн дансыг хуулийн хүрээнд удирдах, төлөх шийдвэрийг гаргах.
9.	Хуулийн төслийн 6.1.7 дахь заалт	6.1.7.хүүхдийн хөгжлийн дансны зарцуулалтад хяналт тавих, жилийн тайланг шалгах.
10.	Хуулийн төслийн 6.1.8 дахь заалт	6.1.8.хөгжлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийн төлбөрт төрөөс олгосон дүн хангалтгүй тохиолдолд зөрүүг сайн дурын үндсэн дээр гаргах.

Хүснэгтэд дурдсанчлан төсөлд тусгагдсан иргэнд эрх үүрэг олгосон заалтууд нь шаардлагатай гэж үзвэл иргэн заавал нэмэлт зардал гаргахгүйгээр өөрийн хүсэл зорилго, мэдлэг боловсрол дээр тулгуурлан шийдвэр гаргах, Үндсэн хуулиар олгогдсон сурч боловсрох эрх болон үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх журамт үүргийн хүрээнд хийгдэх учир нэмэлт зардал гарах зохицуулалт биш байна.

Иймд Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх цаг хугацааны ачаалал бага хэмжээгээр нэмэгдэх боловч болон нэмэлт зардал үүсэх зохицуулалт байхгүй тул тусгайлан зардал тооцох хэрэгцээ шаардлагагүй байна.

Дөрөв.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад үүсэх зардал болон улсын төвөст үүсэх зардал.

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- ✓ Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- ✓ Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- ✓ Гарах зардлыг урьдчилан тооцох;
- ✓ Зардлыг нэгтгэн тооцох;
- ✓ Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хуулийн төсөлд төрийн байгууллагад үүрэг болгосон буюу шууд зардал үүсгэх болон шууд бусаар зардал үүсгэж болзошгүй гэж үзэж болох агуулга бүхий дараах зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

№	Хуулийн төслийн зүйл заалтын дугаар	Зохицуулалт
1.	Хуулийн төслийн 7.1.1 дэх заалт	7.1.1.хүүхдийн хөгжлийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөгжлийн төв, дэд бүтцийн төсвийг батлах.
2.	Хуулийн төслийн 7.1.2 дахь заалт	7.1.2.Улсын төсөв, Үндэсний баялгийн сангаас жил бүр олгох хүүхдийн хөгжилд зарцуулах хувь хэмжээг тогтооно.
3.	Хуулийн төслийн 7.1.3 дахь заалт	7.1.3.тухайн жилд зарцуулагдах нэг хүүхдэд ногдох хүүхдийн хөгжлийн нэрийн дансанд байрших санхүүжилтийн дэмжлэгийг бүс нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хүүхдийн тоо зэргийг харгалзан батална.
4.	Хуулийн төслийн 9.1.3 дахь заалт	9.1.3.хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн бүртгэлийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх.
5.	Хуулийн төслийн 10.1 дэх хэсэг	10.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь тухайн орон нутгийн хүүхдийн тоо, нутаг дэвсгэрийн байршил, барилга байгууламжийн хүрэлцээ дээр тулгуурлан энэ хуулийн 4.1-т заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулах сургалт, дугуйлан зохион байгуулах хүүхдийн хөгжлийн төвийг төвлөрсөн болон төвлөрсөн бусаар байгуулна.
6.	Хуулийн төслийн 11.1 дэх хэсэг	11.1.Энэ хуулийн 12.4-т заасан хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааг дэмжих бүтээн байгуулалт, дэд бүтэц, тоног төхөөрөмжтэй

		холбоотой төсвийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэх.
7.	Хуулийн төслийн 12.3 дахь хэсэг	12.3.Энэ хуулийн 9.1.3-т заасан мэдээллийн санд харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа хувь, хүн хуулийн этгээдийн бүртгэлийг оруулах ажлыг зохион байгуулах.
8.	Хуулийн төслийн 12.4 дэх хэсэг	12.4.Харьяалах нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, түүнд шаардлагатай барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг бүтээн байгуулахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгах.
9.	Хуулийн төслийн 12.5 дахь хэсэг	12.5.Энэ хуулийн 10.1-т заасан хөгжлийн төвийг харьяалах нутаг дэвсгэртээ байгуулахдаа тухайн орон нутгийн сургууль, цэцэрлэг, соёлын төв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн барилга байгууламжийг тэргүүн ээлжид ашиглах тухай шийдвэрийг гаргах.
10.	Хуулийн төслийн 12.6 дахь хэсэг	12.6.Харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа энэ хуулийн 10.1-т заасан хүүхдийн хөгжлийн төвийн жишиг дүрмийг баталж мөрдүүлэх, түүнд хөгжлийн үйл ажиллагаа явуулах хувь хүн, хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн сонгон шалгаруулан гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, холбогдох санхүүжилтийг шийдвэрлэх.
11.	Хуулийн төслийн 16.1 дэх хэсэг	16.1.Хүүхдийн хөгжлийн төвийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн санхүүжилт нь орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс бүрдэнэ.
12.	Хуулийн төслийн 16.2 дахь хэсэг	16.2.Хүүхдийн хөгжлийн төв дээр үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн сургалтын төлбөрийн хэмжээг тухайн жилийн санхүүжилт, зах зээлийн үзүүлэлт зэрэг дээр тулгуурлан нэг хүүхдэд оногдох дэмжлэгийн хэмжээг энэ хуулийн 9.1-т заасан төрийн захиргааны төв байгууллага батална.
13.	Хуулийн төслийн 16.3 дахь хэсэг	16.3.Хүүхдийн хөгжлийн төв дээр үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн санхүүжилтийг тухайн шатны засаг дарга талуудын хооронд байгуулагдсан гэрээнд заасны дагуу сар бүрийн 25-ны өдрийн дотор тухайн орон нутгийн хүүхдийн хөгжил хариуцсан төрийн захиргааны байгууллагын санхүүжилтийн мэдэгдлийг үндэслэн олгоно.

Төсөлд тусгагдсан заалтууд нь өмнө нь төрийн байгууллагад хуулиар ногдуулсан чиг үүргийн хүрээнд илүү тодорхой зохицуулалтыг хуульчилсан бөгөөд зөвхөн хүүхдэд суурь боловсрол олгох, хүүхэд хамгааллын чиглэлээр явуулдаг байсан үйл ажиллагааны чиг үүрэгт хүүхдийн хөгжлийн чиглэлийн чиг үүргийг л нэмэгдүүлж илүү тодорхой болгож өгсөн тул төрийн байгууллагад нэмэлт үүрэг ногдуулж, зардал үүсгэхгүй зохицуулалтууд байна.

Өөрөөр хэлбэл төсөв батлах, тухайн орон нутагтаа хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах чиг үүрэг, нэгэнт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, сургалтын байгууллагын чиг үүрэгт хүүхдийн хөгжлийн чиглэлээр анхаарч ажиллах чиг үүргийг илүү тодорхой болгож өгсөн.

Улсын төсвөөс гарах санхүүжилт нь тухайн жилийн улсын төсөв дээр нэмэлт зардал болохгүй бөгөөд Үндэсний баялгийн санд хуримтлагдсан хөрөнгөөс тухайн жилийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт нөхцөл байдал дээр тулгуурлан жил бүр гаргахаар тусгагдсан байна.

Тухайлбал тус хууль 2025 онд батлагдаж 2026 оноос хэрэгжиж эхэлбэл Монгол улсад 6-16 насны 800 мянга орчим хүүхэд байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн 1 сарын хичээлээс гадуурх сургалтын зардлыг дунджаар 50,000 төгрөг байхаар төлөвлөж 6 сарын хугацаанд хамрагдах төсөвт өртгийн 300,000 төгрөгийг төрийн зүгээс дэмжлэг үзүүлж жилдээ 240 орчим тэрбум төгрөгийг Ирээдүйн өв сан болон Хуримтлалын сангаас зарцуулах шаардлага гарч байна.

Хүний нөөцийн хувьд аймаг дүүргийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засгийн газар, Улсын их хурал нь төсөлд тусгагдсан зохицуулалтыг хариуцсан нэгж, газар хэлтэс, албатай болно.

Өөрөөр хэлбэл дээр дурдсан ажлын алба, газар хэлтэс, нэгж албадын хариуцсан ажлын чиг үүрэгт төсөлд тусгагдсан төрийн байгууллагын үүргийг хамааран гүйцэтгэх үүрэг байгаа тул төсөл батлагдсанаар төрийн байгууллагад хүний нөөцийн нэмэлт хэрэгцээ шаардлага гарахгүй бөгөөд улмаар төрийн байгууллага, төсөвт нэмэлт зардал үүсэхгүй гэж тооцохоор байна.

Тав.Дүгнэлт

“Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлал” болон түүнтэй уялдуулан боловсруулсан хуулийн төслийн шинэчилсэн зохицуулалтууд нь хүүхдийн эрх, хүүхдийн хөгжлийн чиглэлээр бусад хууль тогтоомжуудын хүрээнд орхигдуулсан байсан зохицуулалтуудыг илүү боловсронгуй болгосон, нарийвчилсан агуулгатай байгаагаараа хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад зардал үүсэхээр шинэ буюу нэмэлт үүрэг ноогдуулаагүй байна.

Нөгөө талаас үзэл баримтлалд дурдсанчлан хуулийн төслийн холбогдох зохицуулалтууд нь Монгол улсын иргэний сурч боловсрох эрх болон хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалах үйл ажиллагааны үндсэн арга механизм нь хүүхэд бүр хөгжлийн үйл явцад тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх, хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хүүхдийн хөгжлийн үйл

ажиллагааг төрөөс дэмжих, санхүүжүүлэх, зохион байгуулах бодлогыг хэрэгжүүлж нийгэм эдийн засагт эерэг үр нөлөө үзүүлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага, хуулийн этгээдэд шинээр хүний нөөцийн хэрэгцээ шаардлага гарахгүй, улмаар хүний нөөцтэй холбоотойгоор цалингийн зардал гарахгүй гэж үзлээ.

Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь ихэнхдээ тухайн зохицуулалтыг боловсронгуй болгосон, зарим нэмэлт үүрэг нь одоо мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтын зардлын хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлж болох үүрэг байх тул хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал нэмэхгүй, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд аливаа нэмэлт зардал гарахгүй гэж дүгнэж байна.

---o0o---

Хууль санаачлагч нар



УИХ-ын гишүүн

Мягмарсүрэнгийн БАДАМС...



УИХ-ын гишүүн

Хүрэлбатырын БААСАНЖ...



УИХ-ын гишүүн

Даваасамбуугийн ГАНМАА



УИХ-ын гишүүн

Мөнгөнцогийн ГАНХҮЛЭГ



УИХ-ын гишүүн

Батжаргалын ЗАЯА

Боловсруулж буй

Өргөн баригдсан

Хэлэлцэх эсэх

Ажлын хэсэг

Анхны хэлэлцүүлэг

Эцсийн хэлэлцүүлэг

Батлах

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 ОНЫ 10-Р САРЫН 24 ӨДӨР

УЛААНБААТАР

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.06.22

Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжихэд чиглэсэн “Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай” хуулийн төслийн хэлэлцүүлгийг хүүхдийн өмнө үүрэг хүлээгч байгууллага, албан тушаалтнуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, харилцан туршлага солилцох, хүүхдийн хөгжлийн сайн жишгийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор хэлэлцүүлгийг 2025 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 10:00–16:00 цагийн хооронд Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион байгууллаа.

Хэлэлцэх асуудал: “Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай” хуулийн төслийн талаар :

Хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн М.Бадамсүрэн, Ц.Идэрбат, Л.Соронзонболд, С.Эрдэнэбат нар болон Дорнод аймгийн ЗДТГ, Нийгмийн бодлогын хэлтэс, Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар, Боловсролын газар, Биеийн тамир, спортын газар, “Хүн болох багаасаа” төслийн байнгын ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Д.Бүжин, багш сурган хүмүүжүүлэгчид болон хүүхдийн өмнө үүрэг хүлээгчид өргөн бүрэлдэхүүнээр оролцож хуулийн төсөлд санал өгч ажилалаа.

Хэлэлцүүлгийг нээж Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн дарга бөгөөд Аймгийн Засаг дарга Ш. Ёл: Дорнод аймагт хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй ажил, хүүхдийн авьяас хөгжлийн төвийн дугуйлангийн үйл ажиллагааг танилцуулж нээлтийг хийлээ Засаг дарга Ш. Ёл нь хэлсэн үгэндээ Хүүхэд бол бидний ирээдүй, улс орны ирээдүйн иргэн. Тиймээс тэдний хөгжлийг дэмжих бодлого, хууль эрх зүйг бодитоор хэрэгжүүлэх шаардлагатай байна” хэмээн онцлов.

Үүний дараагаар УИХ-ын гишүүн М. Бадамсүрэн “Хүүхдийн хөгжлийг дэмжих” хуулийн төслийн танилцуулга мэдээллийг танилцуулав. Тэрээр хэлсэн үгэндээ “Энэхүү хууль нь хүүхдийн хөгжлийг зөвхөн боловсролоор хязгаарлахгүй, авьяас, сонирхол, оролцоог бүх талаар дэмжих цогц зохицуулалт болно” гэв.

Мөн хэлэлцүүлгийн үеэр Дорнод аймагт хэрэгжиж буй Хүн болох багаасаа төслийн авьяас сургалтын талаарх тайлан мэдээллийг ажлын хэсгийн нарийн бичиг Д.Бүжин, Хүн болох багаасаа төслийн Гадаад хэлний дугуйлангийн үйл ажиллагааг багш О. Мөнхзул, Хүн болох багаасаа төслийн спортын дугуйлан, секцийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг төслийн нарийн бичиг Г. Наранбаатар нар “Орон нутагт хүүхдийн авьяас, гадаад хэл, спортын хөгжлийг дэмжсэн нь эцэг эх, багш нарын оролцоог нэмэгдүүлж байна, мөн Хүүхдүүд өөрийгөө илэрхийлэх, хамгаалах чадвар мэдэгдэхүйц сайжирч байгаа талаар танилцуулга мэдээлэлдээ дурдсан юм.

Танилцуулга мэдээллийн дараагаар сурган хүмүүжүүлэгчид болон хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн дунд хүүхдийн хөгжлийн чиглэлээр тулгамдаж буй асуудал, хүүхдийн хөгжлийн тухай хуулийн төсөлд санал өгч ажиллалаа.

Нээлттэй хэлэлцүүлгийн үеэр

- Аймгийн Боловсролын газрын дарга Ариунаа: “Хуулийн хэрэгжилтэд санхүүжилтийн тодорхой эх үүсвэрийг тусгах шаардлагатай байна.
- 8 дугаар сургуулийн захирал М.Наранжаргал : “Дугуйлан, секцийн үйл ажиллагааг тогтвортой санхүүжүүлэхгүй бол үр дүн буурна.”
- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн Д. Ундраа хэлэхдээ хүүхдийн хөгжлийн тухай хуулийн зорилгыг сайжруулах, Хуулийн үйлчлэх хүрээнд насыг 6-16 нас гэж заасныг анхаарах, Нэр томъёоны тайлбарыг "#Хүүхдийн хөгжлийг дэмжих, үйлчилгээ үзүүлэх, байгууллагад тавигдах нийтлэг шаардлага" батлагдсантай холбоотой дахиж боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй болон дотуур байрны хүүхэд, зорилтот бүлгийн хүүхдийн оролцоог хангах, Хөгжлийн хөтөлбөрийн стандарт, мэргэжилтэнд тавих шаардлага, байгууллагад тавигдах шаардлага, санхүү, татварын дэмжлэг, Хүүхэд хамгааллын бодлого, хүүхдийн аюулгүй байдлыг хангах хууль, тогтоомжийн хэрэгжилт, Төр хувийн хэвшил, эцэг эхийн үүрэг оролцоо, хариуцлага, санхүүжилт түүнд тавих хяналт, ил тод байдалд анхаарах шаардлагатай гэж үзэж байна.
- Эцэг эхийн төлөөлөл: “Хүүхдийн аюулгүй байдал, өөрийгөө хамгаалах чадварыг илүү бодит хөтөлбөрөөр дэмжих хэрэгтэй.”
- Дугуйлан сургалтад хамрагдах хүүхдийн нас заахгүй байх
- Эцэг эхчүүдийн оролцоо дэмжлэгийг хуулинд тусгаж өгөх
- Шаардлагатай тоног төхөөрөмж сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах
- Зорилтот бүлгийн хүүхдүүдийг төрөөс 100 хувь даах талаар тусгах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг харах хөгжүүлэх өдөр өнжүүлэх төвтэй болох
- Зүүн бүсийн зуслан, хүүхдийн ордонг байгуулах нэн шаардлагатай байгаа талаар
- Зүүн бүсийн зуслан, хүүхдийн ордонгоор дамжуулан хүүхдийн хөгжлийг дэмжих бүсчилсэн сургалт зохион байгуулах
- Хүүхдийн хөгжлийг дэмжих бодлого нь салбар хоорондын уялдаатай байх
- Хуулийн төсөлд орон нутгийн онцлог, хэрэгцээг тусгах нь чухал.
- Хүүхдийн хөгжлийн төв, дугуйлангийн үйл ажиллагааг тогтвортой дэмжих шаардлагатай. талаарх саналыг тус тус хэллээ.

Мөн хэлэлцүүлгийн үеэр саналыг бичгээр авч нэгтгэн ажилласан бөгөөд хавсралтаар саналыг хавсаргав.

УИХ-ын гишүүн М.Бадамсүрэн: “Та бүхний гаргасан санал хуульд бодитоор тусгагдах боломжтой. Орон нутгийн дуу хоолой хамгийн чухал”, хэмээн хэлэлцүүлгийг хаав.

Хэлэлцүүлгээр гарсан санал, дүгнэлт:

- ✓ Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай гэж үзэв.
- ✓ Хүүхдийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоход орон нутгийн санал, туршлагыг тусгах нь зүйтэй гэж дүгнэв.
- ✓ “Хүн болох багаасаа” төслийн үр дүнг цаашид өргөжүүлэх, тогтвортой хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэв.

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН САНАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6.4-т заасны дагуу цахим хэлбэрээр явуулахаар 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр d.parliament.mn цахим хуудсанд байршуулж, санал авах ажлыг зохион байгуулан ажилласан.

2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар тус хуулийн төсөлд 23 санал, 280 дэмжлэг ирүүлсэн байна. Үүнд:

Д/д	Нэр	Ирүүлсэн санал	Хуулийн төсөлд тусгасан эсэх
1	ЭНХЗУЛ	Хүүхэд хөгжлийн хөтөлбөрүүдийн ач холбогдлыг таньж, хуульчлахаар ажиллаж буйд талархалтай байна. Гэвч хуулийн зорилго хүүхдийн хөгжлийг зөвхөн хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хязгаарлаж буй мэт явцуу харагдаж байна.	Тусгасан
2	ӨЛЗИЙСАЙХАН	Хүүхдийн хөгжлийг НҮБ-ын Хүүхдийн сан 0-18 насанд нь цогцоор авч үздэг. Иймээс хүүхдийн хөгжлийг эрүүл мэнд, хоол тэжээл, хөгжил боловсрол, хамгаалал, асаргаа халамжийн цогц үйлчилгээг үзүүлэхэд боломжийг бүрдүүлэх чиглэлээр тодорхойлох. Хүүхдийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулах саналтай байна.	Тусгасан
3	ЭНХЗУЛ	Хүүхдийн хөгжлийн хөтөлбөрүүд гэж энэ тодорхойлолтыг оруулах нь зүйтэй. Дээр бичсэнчлэн хүүхдийн хөгжил гэж хичээлээс гадуурх үйл ажиллагааг хэлнэ гэж байгаа мэт явцуу ойлгогдож байна.	Тусгасан
4	ЭНХЗУЛ	Багш, чиглүүлэгч, мэргэжилтнүүдийг бэлтгэх, гэрчилгээжүүлэх гэж нэмэх	Тусгаагүй

5	ЭНХЗУЛ	... сургалт, хөгжлийн үйл ажиллагаа явуулж буй гэх	Тусгаагүй
6	МӨНХБАТ	Эх Монгол хэлээ үзэж сурсаны дараа 10-12 насанд гадаад хэл сургах нь эх хэлээ хамгаалсан асуудал тул анхааралтай журамд тусгах нь чухал	Тусгаагүй
7	МӨНХБАТ	Эх түүх эрүүл ахуй, Монгол ёс заншил гэсэн хичээлүүдийг бага, дунд ангид түлхүү оруулж хичээлийн хөтөлбөрт оруулах нь чухал байна.	Тусгасан
8	СОЁЛМАА	Хоцрогдол арилгах хөтөлбөр / үүнд: хичээлийн болон оюун ухаан, танин мэдэхүйн, хүүхдийн хөгжлийн г.м/	Тусгасан
9	БАЯРБАТ	сайн дурын үндсэн дээр хэрэгжих уг зохицуулалт нь нөгөө талаараа албадлагын үндсэн дээр болон дарамт шахалтаар тухайн үйл ажиллагаанд оролцоогүй байх агуулгыг илэрхийлдэг. Иймд албадлагагүй байх баталгаа зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. иймд тус агуулгаар хуулийн зохицуулалтыг өргөжүүлэх, зүйл заалт байдлаар нэмэх эсхүл бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар зохицуулах нь зүйтэй.	Тусгасан
10	ЭНХЗУЛ	6 сар гэж авдаг нь ямар үндэслэлтэй вэ? Нэг улирал буюу 3 сараар доод тал нь явах зохицуулалттай байвал ямар вэ? Ихэнх хөгжлийн хөтөлбөрүүд нэг улирал түүнээс дээш хугацаатай төлөвлөгдөн зохион байгуулагддаг	Тусгаагүй
11	ЭНХЗУЛ	Эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэгт - Хүүхдийн мөнгийг хүүхдийн хөгжлийн төвийн сургалтуудад зарцуулах боломжийг хүүхдүүддээ олгох, хүүхдүүдэд ялангуяа ахлах ангийн	Тусгасан

		хүүхдүүдэд Хүүхдийн мөнгөө өөрийн сонирхол, хэрэгцээний дагуу хөгжүүлэх хөтөлбөрүүдэд зарцуулах эрхийг бий болгох тал руу судалж тусгах	
12	БАЯРБАТ	"... зөрүүг сайн дурын үндсэн дээр гаргана." гэж заасан нь Хүүхдийн эрхийн конвенцийн 2 дугаар зүйлийн хамрах хүрээ өөрөөр хэлбэл "тэгш байдлын зарчим, ялгаварлан гадуурхалтыг хориглох" заалттай агуулгын хувьд зөрчилтэй хэмээн үзэж байна. Учир нь дунджаас доогуур эсхүл бага орлоготой, эмзэг бүлгийг бодитоор ялгаварлан гадуурхах өндөр эрсдэлтэй байна.	Тусгаагүй
13	ЭНХЗУЛ	Хүүхдийн төлөө фонд, Хүүхдийн мөнгө зэрэг одоо улсын төсөвт хүүхэд хөгжлийн зорилгоор суугддаг төсвийг хүүхэд хөгжлийн төв рүү уялдуулахад анхаарах. Үндэсний баялгийн сан нэг эх үүсвэр нь дунд хугацаандаа байж болох ч өнөөгийн нөхцөлд шууд татах ганц эх үүсвэр байдалтай оруулах хэтэрхий эрсдэлтэй	Тусгаагүй
14	ЭНХЗУЛ	8 дугаар зүйл. Засгийн газрын эрх, үүрэг Хүүхэд хөгжлийн төвийн тогтвортой, үр дүнтэй үйл ажиллагааг хангахад тухайн орон нутагт энэ чиглэлээр ажилласан туршлагатай, хүлээн зөвшөөрөгдсөн хувь хүн, ТББ, хувийн хэвшилтэй хамтран ажиллах буюу Төр - Хувийн хэвшил - Иргэний нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх гэх тусгайлан оруулах! Төр менежементээ авч явна гэвэл нийслэлийн Hub төв, орон нутаг, дүүргүүдэд байдаг ЖДҮ төв, бизнес төв г.м олон үр дүнгүй төвүүд шиг болно	Тусгасан
15	ЭНХЗУЛ	Хүүхдийн төлөө фонд, Хүүхдийн мөнгө зэрэг одоо улсын төсөвт хүүхэд хөгжлийн зорилгоор суугддаг төсвийг хүүхэд хөгжлийн төв рүү уялдуулахад анхаарах. Үндэсний баялгийн сан нэг эх	Тусгасан

		үүсвэр нь дунд хугацаандаа байж болох ч өнөөгийн нөхцөлд шууд татах ганц эх үүсвэр байдалтай оруулах хэтэрхий эрсдэлтэй	
16	ЭНХЗУЛ	Мэдээллийн санг бүрдүүлэх, тогтмол шинэчилж байх, иргэд хэрэглэгчид өөрсдөө үнэлгээ өгөх боломжоор хангах. Зөвхөн төрийн байгууллага ИН, ТББ, ААН-үүдээ үнэлвэл субъектив, ашиг сонирхлын зөрчил орох эрсдэл өндөр	Тусгаагүй
17	ЭНХЗУЛ	Барилга байгууламжийг заавал шинээр барих биш, одоо байгаа барилга байгууламжуудыг засварлах, зориулалтыг өөрчлөх г.м-р хурдан хугацаанд ажиллагаанд оруулах боломжуудыг нээх	Тусгасан
18	ЭНХЗУЛ	Энд заасан хуулиндаа хүүхдийн хөгжлийн чиглэлээр тухайн орон нутагтаа ажилласан туршлагатай, хүлээн зөвшөөрөгдсөн хувь хүн, ААН-үүд ажиллах боломжийг хангах заалтыг давхар оруулж өгөхгүй бол яг хүүхдийн төлөө ажиллах сэтгэлтэй, зүтгэлтэй хүмүүс нь хуулийн шаардлага хангахгүй гээд ажиллах боломжгүй болох эрсдэлтэй. Нөгөө талаас шаардлага нь хэт өндөр юмуу явцуу байвал чадвартай, чадамжтай баг, хувь хүмүүс орж ирэх сонирхол төрөхгүй байх магадлалтай	Тусгаагүй
19	ЭНХЗУЛ	Боловсролын байгууллагуудын багш, ажилтнууд хүүхдийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд нэмэлт цалин урамшуулал авах байдлаар оролцох боломжийг нээх	Тусгасан
20	ЭНХЗУЛ	Мэргэшсэн гэдгийг яаж баталгаажуулах вэ? Төрийн ямар байгууллага? ОУ-ын ямар гэрчилгээ зэргийг дотоодын ямар шалгууруудтай дүйцүүлэх вэ?	Тусгасан

21	СОЁЛМАА	энэ чиглэлээр мэргэшсэн, мэргэжлийн үнэмлэх, боловсролын бичиг баримттай байна.	Тусгасан
22	СОЁЛМАА	хамтарсан багийн гишүүдэд журмаар үүрэг болгож оруулах	Тусгасан
23	ЭНХЗУЛ	Хүүхдийн төлөө сан - үүнд хувийн хэвшил хандив, санхүүжилт өгвөл Татварын хөнгөлөлт эдэлдэг байх нөхцлийг Татварын тухай хуульд тусгах Хүүхдийн мөнгөний зарцуулалтыг мөн уях	Тусгаагүй

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.10 дахь хэсэгт зааснаар “Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөллөөс санал авч, хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргах” асуудал уг хуулийн төслөөр энэ асуудлыг Сангийн яам хариуцан ажиллах тул Засгийн газрын санал дүгнэлтэд болон хуулийн төслийг өргөн мэдүүлэхэд Сангийн яам зөвшөөрөл өгдөг тул тусад нь санал авах шаардлагагүй гэж үзлээ.



**ТОГЛО ИНЭЭ СУР
ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ТӨВ НҮТББ**

Сонгинохайрхан дүүрэг, 34-р хороо,
5-р байр, 5 тоот Утас: 80108038,

И-мэйл: piayiaughieartn.ub@gmail.com

Огноо 2026-02-29 № 4/08
танай _____-ны № _____-т

“ УИХ-ын гишүүн М. Бадамсүрэн танаа ”

Таны санаачлан боловсруулж буй “Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай” хуулийн төслийг судлан үзээд манай байгууллагаас хүүхдийн хөгжлийн бодлого, нийгмийн ажлын практик, судалгаанд үндэслэн боловсруулсан санал, дүгнэлтийг хүргүүлж байна.

“ТОГЛО ИНЭЭ СУР” хүүхэд, залуучуудын хөгжлийн төвөөс тус хуулийн төсөл нь хүүхдийн хөгжлийг зөвхөн хичээлээс гадуурх үйл ажиллагааны хүрээнд хязгаарласан, цогц бодлогын шинжийг бүрэн хангаагүй гэж үзэж байгаа бөгөөд хүүхдийн хөгжлийг илүү өргөн хүрээнд, салбар хоорондын уялдаа бүхий байдлаар зохицуулах шаардлагатай гэж дүгнэж байна.

Иймд хүүхдийн хөгжлийг бие бялдар, оюун ухаан, сэтгэл зүй, нийгмийн оролцоог хамарсан цогц ойлголтоор авч үзэх, эрсдэлт бүлгийн хүүхдэд чиглэсэн бодлого, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нэгдсэн үйлчилгээний тогтолцоог хуульд тусгах шаардлагатай талаарх дэлгэрэнгүй санал, зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Манай байгууллагын зүгээс хүүхдийн хөгжлийн чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжилтийг сайжруулахад хамтран ажиллахад нээлттэй болохыг илэрхийлье.

Хавсралт:

1. Хуулийн төсөлд өгөх санал, дүгнэлт: 2 хуудас

Гүйцэтгэх захирал



/Ш.Насанбурмаа/

Таны санаачлан боловсруулсан “Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай” хуулийн төслийг судлан үзээд нийгмийн ажилтан, судлаачийн хувьд дараах бодлогын шинжтэй санал, дүгнэлтийг хүргүүлж байна.

Нэг. Ерөнхий дүгнэлт

Тус хуулийн төсөл нь “хүүхдийн хөгжил” гэсэн өргөн хүрээтэй ойлголтыг зөвхөн хичээлээс гадуурх сургалт, дугуйлан, төвийн үйл ажиллагаагаар хязгаарласан нь концепцийн хувьд хэт явцуу, салбарын бодлогын үндсэн зорилгоос зөрсөн байна. Тухайлбал, хуулийн зорилго, нэр томъёоны тодорхойлолтод хүүхдийн хөгжлийг зөвхөн чөлөөт цаг, сургалтын нэмэлт үйл ажиллагаатай холбон тодорхойлсон нь хүүхдийн хөгжлийг цогц байдлаар авч үзэх зарчимд нийцэхгүй байна.

Иймд уг хуулийн төсөл нь:

- Хүүхдийн хөгжлийн суурь ойлголтыг хязгаарласан
- Хүүхдийн хөгжилд нөлөөлөх гол системүүдийг орхигдуулсан
- Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, сэтгэл зүй, гэр бүлийн орчны нөлөөллийг тусгаагүй байна.

Хоёр. Суурь концепцийн түвшний санал

1. Хуулийн зорилго, хамрах хүрээг өргөтгөх

Хүүхдийн хөгжлийг дараах байдлаар цогцоор нь тодорхойлох шаардлагатай:

- Бие бялдар
- Оюун ухаан
- Сэтгэл зүй
- Нийгмийн хөгжил
- Гэр бүлийн орчин

Хуулийн зорилгыг зөвхөн “хичээлээс гадуурх үйл ажиллагаа”-наас “хүүхдийн хөгжлийг бүхэлд нь дэмжих бодлогын зохицуулалт” болгон өөрчлөх шаардлагатай.

2. Хүүхдийн хөгжлийн нэгдсэн тогтолцоог хуульчлах

Одоогийн төсөлд үйлчилгээний тогтолцоо биш, зөвхөн үйл ажиллагаа зохион байгуулалт тусгагдсан байна.

Иймд дараахыг тусгах шаардлагатай:

- Салбар хоорондын (боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал) нэгдсэн үйлчилгээ
- Кейс менежментийн тогтолцоо
- Хүүхэд бүрт чиглэсэн хувь хүний хөгжлийн төлөвлөлт

3. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг төвд тавих

Одоогийн төсөлд эрсдэлт бүлгийн асуудал хоёрдогч түвшинд тусгагдсан байна.

Харин:

- Ядуу өрхийн
- Хөгжлийн бэрхшээлтэй
- Хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хүүхдүүдийг хуулийн гол зорилтот бүлэг болгон тодорхойлох шаардлагатай.

4. Урьдчилан сэргийлэх болон эрт оролцоог тусгах

Хуулийн төсөлд:

- 0–5 насны хөгжил
- Эцэг эхийн боловсрол
- Гэр бүлийн орчин бараг тусгагдаагүй байна.

Иймд:

- Эрт үеийн хөгжлийн үйлчилгээ (early childhood development)
- Эцэг эхэд чиглэсэн дэмжлэг зэрэг заалтыг шинээр нэмэх шаардлагатай.

5. Нийгмийн ажилтны үүргийг тусгах

Одоогийн төсөлд нийгмийн ажилтны оролцоо бараг тусгагдаагүй байна.

Гэтэл бодит байдал дээр:

- Хүүхдийн хөгжлийн асуудал нь нийгмийн ажилтны үндсэн чиг үүрэгтэй шууд холбоотой.

Иймд:

- Сургууль, хороо, орон нутаг дахь нийгмийн ажилтны үүрэг
- Кейс удирдлага
- Хүүхдийн хамгаалалтай уялдсан хөгжлийн үйлчилгээ зэргийг хуульд тусгах шаардлагатай.

6. Санхүүжилтийн зарчимд тэгш байдлыг хангах

Төсөлд эцэг эхээс нэмэлт төлбөр гаргах боломжийг тусгасан нь нийгмийн ялгааг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Иймд:

- Эрсдэлт бүлгийн хүүхдэд бүрэн үнэ төлбөргүй үйлчилгээ
- Санхүүжилтийн ялгаатай (targeted) механизм тусгах шаардлагатай.

7. Хяналт, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх

Одоогийн төсөлд хяналт нь:

- чанарын бус
- системгүйбайна.

Иймд:

- Хүүхдийн хөгжлийн индекс
- Үр дүнгийн шалгуур үзүүлэлт
- Хараат бус үнэлгээ зэрэг механизмыг тусгах шаардлагатай.

Гурав. Дүгнэлт

Энэхүү хуулийн төсөл нь хүүхдийн хөгжлийг дэмжих чухал эхлэл боловч одоогийн байдлаар хэт явцуу хүрээнд, үйлчилгээний нэг хэлбэрийг зохицуулсан шинжтэй байна.

Иймд уг хуулийг:

- Хүүхдийн хөгжлийг цогцоор нь авч үзсэн
- Салбар хоорондын уялдаа бүхий
- Эрсдэлт бүлгийг төвд тавьсан
- Урьдчилан сэргийлэх чиглэл давамгайлсан суурь бодлогын хууль болгон шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Дээрх санал, дүгнэлтийг хуулийн төсөлд тусган авч үзнэ гэдэгт итгэлтэй байна.

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

Санал гаргагч: Гүрэн Инновацийн Сургууль (Gurun Innovation School)

НЭГ. Хуулийн төслийн санаачилгыг дэмжих тухай

Гүрэн Инновацийн Сургуулийн зүгээс Монгол Улсад анх удаа хүүхдийн хичээлээс гадуурх үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжих, санхүүжүүлэх зохицуулалт бүхий "Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай" хуулийн төслийг боловсруулж байгаад гүн талархал илэрхийлж, **энэхүү хуулийн санаачилгыг бүрэн дэмжиж байгаагаа** үүгээр илэрхийлж байна. Хүүхэд бүрийн хүсэл сонирхолд тулгуурлан авьяас чадварыг нь хөгжүүлэх нь глобал нийгэмд хариуцлагатай, өндөр боловсролтой иргэнийг бэлтгэхэд нэн чухал алхам юм.

Гэсэн хэдий ч бидний зүгээс хуулийн төсөлтэй танилцахад орчин үеийн боловсролын салшгүй хэсэг болсон **цахим боловсрол болон хиймэл оюун ухааны (AI)** талаар дурдагдаагүй байгаа тул өөрсдийн туршлага дээр үндэслэн дараах нэмэлт саналыг хүргүүлж байна.

ХОЁР. Цахим боловсрол болон Дижитал бичиг үсгийн талаарх санал

Манай сургууль нь АНУ-ын Стэнфордын Их Сургууль, Пенн Фостер цахим ахлах сургууль болон Английн Этон коллежийн хөтөлбөрүүдийг Монголд нэвтрүүлж, өдгөө цахим ахлах сургуулиар дамжуулан орон даяар хүүхдүүдэд чанартай боловсролыг орон зай, санхүүгээс үл хамааран хүртээмжтэйгээр хүргэж байгаа туршлагатай билээ.

- **Цахим орчныг хөгжлийн талбар болгох:** Хуулийн төслийн 4.1.3 болон 13 дугаар зүйлд "Хүүхдийн хөгжлийн төв"-ийг зөвхөн барилга байгууламжид түшиглэн байгуулахаар заасан байна. Үүнийг өргөжүүлж **"Цахим хөгжлийн талбар/орчин"**-ыг албан ёсоор хуульд тусгах шаардлагатай байна. Хөтөлбөрийг цахим талбарт шилжүүлснээр Монголын хаана амьдарч байгаагаас үл шалтгаалан хүүхэд бүр байгаа газраасаа, хүссэн үедээ хөгжлийн дугуйлан, сургалтад хоцролгүй хамрагдах бүрэн боломжтой юм.

- **Дижитал бичиг үсгийн агуулга:** Хуулийн төслийн 5.1-д заасан хичээлээс гадуурх хөгжлийн чиглэлүүдэд шинээр **"Digital Literacy буюу Дижитал хэл, бичиг үсэгт суралцах"** гэсэн чиглэлийг нэмж оруулах.
- **Хүртээмжийг нэмэгдүүлэх:** Цахим боловсролыг дэмжсэнээр хуулийн 12.1.4, 13.4-т тусгайлан заасан "хөгжлийн төвөөр очиж үйлчилгээ авах боломж нөхцөл нь хязгаарлагдсан эрсдэлт нөхцөлд байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд" хамгийн тохиромжтой, тэгш хүртээмжтэй шийдэл болж чадна.

ГУРАВ. Хиймэл оюун ухаан (AI) болон технологийн хөгжлийн талаарх санал

- **Хиймэл оюун ухааны чиглэлийг онцлох:** Хуулийн төслийн 5.1.1-д "шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи" гэж ерөнхийлөн заасан байна. Гэвч өнөөгийн хурдацтай хөгжиж буй мэдээллийн эрин зуунд **"Хиймэл оюун ухаан болон мэдээллийн технологи"** гэдгийг тусгайлан онцлох эсвэл технологийн салбар дотроо нарийвчлан тусгах хэрэгцээтэй байна.
- Энэ нь сурагч хүүхэд бүр өөрийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, дижитал эринд амжилттай явахад шаардагдах орчин үеийн ур чадваруудыг эзэмших суурь болох бөгөөд дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын үе тэнгийн хүүхдүүдтэй өрсөлдөх академик амжилтын ялгааг багасгахад шууд нөлөөлнө.

ДӨРӨВ. Дүгнэлт

Монгол Улсад хүүхдийн хөгжлийг дэмжих хууль эрх зүйн орчин бүрдэж буйд бид дахин талархаж байна. Энэхүү хуулийн төсөлд орчин үеийн **цахим боловсрол, дижитал хөгжил болон хиймэл оюун ухааны (AI)** чиг хандлагыг нэмж тусгаснаар хуулийн үйлчлэл илүү бодитой, орчин үеийн шаардлагад нийцсэн, хамгийн гол нь нийт хүүхдүүдэд ялгаваргүй хүрэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Гүрэн Инновацын Сургуулийн хувьд энэхүү хуулийн төслийг амжилттай хэрэгжүүлэхэд өөрсдийн цахим боловсролын олон улсын туршлага, нөөц бололцоонд тулгуурлан нээлттэй хамтран ажиллахад бэлэн байна.

Хүндэтгэсэн,



Б.ДАВААСҮРЭН
ГҮРЭН ИННОВАЦЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ